

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-29
1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/	4-5
2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээлэл	5-17
3. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл /Санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ/	18-29

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны
05 дугаар сарын 28-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 10 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: А.Ганбаатар, Ц.Мөнхбат;
Тасалсан: Т.Мөнхсайхан, Ч.Номин, Ч.Ундрэм.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ж.Золжаргал танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Золжаргал: “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 1
Бүгд: 6
83.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээлэл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од, мөн яамны Харилцаа холбооны бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баясгалан, Кибер аюулгүй байдлын бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Пүрэвням, Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын Төрийн үйлчилгээний дахин загварчлалын хэлтсийн дарга Д.Батбаяр, мөн газрын Салбар дундын зохицуулалт хариуцсан шинжээч Г.Энхтулга, И-Монгол академи УТҮГ-ын Цахим засаглалын хэлтсийн дарга Х.Энхманлай, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, Үндэсний дата төв УТҮГ-ын захирал М.Баттулга, Сангийн яамны

Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, мөн хорооны Зохицуулалтын газрын дарга Т.Батболд, Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ш.Батзаяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ байлцав.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Ч.Анар, Б.Пунсалмаа нарын тавьсан асуултад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од, мөн яамны Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын Төрийн үйлчилгээний дахин загварчлалын хэлтсийн дарга Д.Батбаяр, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Ж.Золжаргал үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл /Санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Г.Нарантуяа, Х.Мөнхзул, мөн комиссын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Тунгалагтамир, Хүний эрхийн боловсролын хэлтсийн ахлах референт Э.Мөнхзул, Олон талт хамтын ажиллагааны хэлтсийн референт Л.Мөнхтулга, Хүний хувийн мэдээлэл хамгаалах хэлтсийн мэдээллийн аюулгүй байдал хариуцсан шинжээч Ө.Энхтөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ байлцав.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Г.Нарантуяа, Х.Мөнхзул нар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Г.Нарантуяа хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ж.Золжаргал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг сонслоо.

Уг асуудлыг 17 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 39 минут үргэлжилж, 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр 17 цаг 49 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 16 цаг 10 минут

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Золжаргал: Байнгын хорооны эрхэм гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Ингээд ирцийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар ирсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар ирсэн байна. Ж.Галбадрах гишүүн ирсэн. Ж.Золжаргал ирсэн. Б.Пунсалмаа гишүүн ирсэн байна. С.Цэнгүүн гишүүн ирсэн байна. Ингээд 54,5 хувийн ирцтэй байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

1.Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

2.Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээлэл сонсох

3 дугаарт нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 24 дэх илтгэл /санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу. Саналтай гишүүн байхгүй байна. Асуудалдаа орьё.

Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Инновац, цахим бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн ажлын хэсэг байгуулах тухай 03 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарыг нэмсүгэй гэсэн ийм агуулгатай тогтоолын төсөл байна.

Энэ бол нөгөө хилийн чанадад амьдарч байгаа монголчуудад төрийн цахим үйлчилгээг хүртээмжтэй болгох, сонгуульд цахимаар оролцох боломжийг

хангахтай холбоотой ажлын хэсэг байгаа. Тогтоолын төсөлтэй холбоотой асуулттай гишүүд байна уу. Асуулт болон үг хэлэх гишүүн байхгүй байна.

Одоо санал хураахад бэлэн байдлыг шалгая. Тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. 6 гишүүн оролцож, 5 гишүүн дэмжсэнээр 83,3 хувиар санал дэмжигдлээ. Баярлалаа.

16.14 цаг.

2 дахь асуудалдаа оръё. **Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, Инновац, Харилцаа холбооны сайдын мэдээлэл сонсох**

Ажлын хэсгийг урьж оруулъя. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Сангийн яамны бүрэлдэхүүнүүд ирсэн байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Алтан-Од, Инновацийн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Мөнхбат, Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ш.Батзаяа, Харилцаа холбоо бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баясгалан, Кибер аюулгүй байдлын бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Пүрэвням, Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын Төрийн үйлчилгээний дахин загварчлалын хэлтсийн дарга Д.Батбаяр, Цахим шилжилтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Салбар дундын зохицуулалт хариуцсан шинжээч Г.Энхтулга, И-Монгол Академийн Цахим засаглалын хэлтсийн дарга Х.Энхманлай, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, Үндэсний дата төвийн захирал М.Баттулга, Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Харилцаа холбооны зохицуулах газрын Зохицуулалтын газрын дарга Т.Батболд, Сангийн яамнаас Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар хүрэлцэн ирсэн байна.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой мэдээллийг Алтан-Од дарга өгнө.

Улсын Их Хурлын 52 дугаар тогтоол буюу 2025 оны улсын төсөв хэлэлцэх үед Улсын Их Хурлын ажлын хэсэг гарч, Тэмүүлэн гишүүн ахалж ажиллаж байсныг та бүхэн санаж байгаа. Тэгээд ажлын хэсгийн дүгнэлтэд Улсын Их Хурлын 52 дугаар тогтоол гарсан. Тэгээд 52 дугаар тогтоолын хүрээнд 4 дүгээр зүйл дээр мэдээллийн технологи, кибер аюулгүй байдал, программ хангамжтай холбоотой өнгөрсөн хугацаанд зарцуулсан нийт төсвийн хэмжээ, үр ашиг, эдгээр системүүдийн ажиллаж байгаа болон ажиллахгүй байгаа байдал зэргийг судлаад, үнэлгээ хийгээд 2025 оны 1 дүгээр улиралд багтааж Улсын Их Хуралд танилцуулах ёстой байсан.

Энэ ажил бол хийгдээгүй, танилцуулагдаагүй байгаа. Тэгээд явцын талаар бол мэдээлэл авсан. Нэлээн их хэмжээний мэдээллийг Баатархүү сайд болон Учрал сайдаас албан бичгээр ингэж авсан байгаа. Тэгэхээр та бүхэндээ мэдээллийг Байнгын хорооны гишүүдэд танилцуулахыг хүсье. Тэгээд аль болохоор гол асуудлуудаа товчхон богино хугацаанд тайлбарлаад, цаашдаа хэзээ

эцэслэж танилцуулах Улсын Их Хуралд хэзээ танилцуулах боломжтой талаар бас нэмэлт мэдээлэл өгөхийг хүсье. Ингээд танилцуулга Алтан-Од дарга хийх үү. 5 номерын микрофон нээж өгнө үү.

П.Алтан-Од: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг эрье.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Төрийн болон орон нутгийн өмчит төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээллийг нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд хяналт тавих, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох зохицуулалт ерөнхийдөө миний илтгэл дээр танилцуулагдана.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны ажлын хэсэг гаргах тушаалаар Шуурхай штабыг томилж ажиллуулж байгаа. Авлигатай тэмцэх 5ш ажиллагааны хүрээнд шил ажиллагааны хэрэгжилтийн удирдлага зохион байгуулалтаар хангаж, шаардлагатай мэдээ, мэдээллийг нэгтгэж, шилийн индексүүдийн үнэлгээг зарлах үүрэг бүхий штабыг шинэчлэн зохион байгуулж ажиллуулж байна.

Нээлттэй мэдээллийн систем shilen.gov.mn дээр одоо 3980 мэдээлэл хариуцагч байгууллагын 4065 албан хаагчийг бүртгэл үүсэж, төрийн байгууллагын мэдээллийг ил тод байлгах үүрэг хүлээж ажиллаж байна. Мэдээллийн хандах эрхийг олгож, сургалтыг үе шаттай зохион байгуулан ажиллаж байгаа. Өнөөдрийн байдлаар 2794 албан хаагчийг сургалтад хамруулан ажиллаж байна.

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар шилэн индексийн дундаж үнэлгээг та бүхэнд бас танилцуулах нь зөв байх. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон 11 яам мэдээллээ оруулсан. 92,6 хувьтай байгаа. Засгийн газрын агентлагуудаас 23 агентлаг мэдээллээ оруулсан 79,6 хувьтай. Нийслэлийн 6 дүүргийн Засаг даргын Тамгын газар мэдээллээ бас учир дутагдалтай оруулж байгаа 60 хувийн биелэлттэй харагдаж байна. Нутгийн захиргааны байгууллага буюу 15 аймгийн Засаг даргын Тамгын газар 78 хувийн биелэлттэй оруулж байна.

Нээлттэй өгөгдлийн жагсаалт, нээлттэй өгөгдлийг нийтлэх хугацааг Засгийн газраас тогтоож өгсөн байдаг. 58 байгууллагын 691 төрлийн нээлттэй өгөгдлийг бий болгож, 53 байгууллага буюу 91,3 хувийг нь бол хэрэгжилт нь хангалттай байршуулсан. 3091 мэдээллийг өгөгдлийг нь 27351 хандалтаар ямар ч байсан шилэн индекс дээр бол хандалтын мэдээллүүд бол нэлээн өргөн цар хүрээтэй орж байгаа. Opendata.gov.mn дээр хандалтын тоо маань нэлээн өссөн. Цаашид бас sudalгаа.gov.mn зэрэг төрийн байгууллагууд төсвийн болоод олон улсын хөрөнгөөр гүйцэтгэсэн судалгааны мэдээллүүдийг байршуулах бас үүрэг хүлээж байгаа. Энэ дээр 2076 судалгааны мэдээллүүд бол байршсан нь харагдаж байна.

2.Төрийн байгууллагын мэдээллийн систем, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын программ хангамж, тоног төхөөрөмжийн худалдан авалт, ашиглалтыг сайжруулах чиглэлээр өгөгдсөн үүргийн дагуу төрийн байгууллагууд ашиглаж байгаа мэдээллийн систем, программ хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын өнөөгийн нөхцөл байдал, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ мэдээллийн аюулгүй байдалд аудит хийж тайланг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд хүргүүлэхээр тогтоол гарсан.

Төсвийн 5671 байгууллагаас 939 буюу 17 хувьд нь Майкрософтын бүтээгдэхүүн ашиглаж байна гэсэн мэдээлэл гарсан. 49017 компьютероос 88,5 хувьд нь бол тус компанийн бүтээгдэхүүнийг ашиглаж байна. 2261 серверээс 79 хувьд нь ашиглаж байгаа учраас энэ бүтээгдэхүүн нийлүүлж байгаа компаниудад цаашид бас бөөний үнээр лицензийн үйлчилгээг хямдруулж авах талаар ажлын хэсэг гаргаж, ажлын хэсэг холбогдох Майкрософт корпорацтай холбогдож цаашид MIU байгуулах хэмжээнд 2026 оны төсөв хэлэлцэх гэж байгаатай холбогдуулаад бас төсвийн саналуудыг боловсруулж, тодорхой үнийг бас бөөний үнээр Засгийн газрын лицензийн түвшинд нь авах, бусад төрийн байгууллагуудтай нийлүүлэх талаар ажиллаж байна. Төсвийн 68 байгууллагаас сүүлийн 2 жилийн хугацаанд Майкрософтын бүтээгдэхүүний ерөнхий гэрээгээр худалдаж авсан судалгаа нь 68 захиалагч байгууллагын нийлүүлэгч Монгол Улсад 4 байгууллага тоо хэмжээгээр 138164 төрлийн 5,5 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүний үйлчилгээг худалдаж авч байгаа юм байна. Мөн салбар хоорондын цахим шилжилтийн нэгдсэн удирдлагаар хангах чиглэлээр цахим эрүүл мэнд салбар бүр дээр цахим шилжилттэй холбоотой бодлогын арга хэмжээ авч ажиллаж байгаа. Монгол Улсын цахим эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах цогц арга хэмжээний төлөвлөгөө салбар дундын хамтарсан хурлыг зохион байгуулах ажлыг 2025 оны 4 дүгээр сард зохион байгуулсан. Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын хамтарсан 2025 оны журам шаардлага шинэчлэн батлах тухай тушаалыг батлуулсан. Захиргааны хэм хэмжээний актыг улсын бүртгэлд бүртгүүлсэн байгаа.

Эрүүл мэндийн салбарын кибер аюулгүй байдлын төлөвшлийн үнэлгээг Эрүүл мэндийн яам, Дэлхийн банкттай хамтран зохион байгуулж хийсэн. Тайлангийн эцсийн дүгнэлт гарахад бэлэн болж байгаа. Хиймэл оюуны үндэсний стратегийн хэлэлцүүлгийг эрүүл мэндийн салбарын дээр зохион байгуулах ажлыг бол Эрүүл мэндийн яамтай харилцан тохиролцоод, энэ сардаа багтааж зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байгаа. Мэдээж И-Монгол дээр эрүүл мэндийн үйлчилгээ авч байгаа цахим эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлчилгээ иргэдэд ер нь хүртээмжтэй хүрч байна уу, цаашид бас цахимжуулах тал дээр Эрүүл мэндийн яам, манай яамтай хамтарсан ажлын хэсэг гаргаж И-монгол дээр эрүүл мэндийн 51 серверээс Улсын бүртгэл, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хил хамгаалах зэрэг олон байгууллагуудаас мэдээллийг нь нэгтгэж, иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар авахад хялбар шуурхай байдлыг хангах зэргээр ажиллаж байна.

Салбар хоорондын цахим шинэчлэлтийг нэгдсэн удирдлагаар хангах үүргийн хүрээнд өргөдөл гомдлын мэдээллийн системийг сайжруулах тал дээр ажиллаж байна. Сайдын А/42 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн иргэд, олон нийттэй харилцах төвд ирүүлсэн өргөдөл, гомдлын санал, хүсэлтийг шийдвэрлэх И-Монголиа нотификашн системээр дамжуулан мэдэгддэг болсон. Ажлын хэсгийн үр дүнг Засгийн газрын хуралдаанаар танилцуулахаар бэлтгэж хүргүүлсэн.

Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргах нэгдсэн систем мэдээллийн системд 1111 төвийн дуудлага, түүний төрөл шийдвэрлэлтийн статистик мэдээлэл, 101, 102, 103, 105 дуудлагын утасны нийт мэдээллийг дашбоард хэлбэрээр авах боломжийг бүрдүүлсэн. Иргэдийн гадаад улсаас дуудлага хүлээн авахад зориулж 70391111 дугаарыг ашиглах саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн. Харин гадаадаас иргэд шууд хандах боломжтой

болж байгаа. 1111 төвийн үйл ажиллагаанд хиймэл оюуныг нэвтрүүлэх ажлыг 2025 оны 4 дүгээр сарын 1-ээс нэвтрүүлж эхэлсэн.

Мэдээллийн сан нэгтгэх хур болон сервисийн мэдээллийг И-Монголиа академид хүргүүлж, иргэд, олон нийттэй харилцах 1111 төвийн нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн мэдээллийн системтэй холбох ажлыг бол зохион байгуулж хийсэн. Өргөдөл, гомдлын мэдээллийн сан, дуудлагын нэгдсэн зохион байгуулалтын чиглэлээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, яам, И-Монгол академи хамтарсан ажлын хэсэг зохион байгуулалтууд авч хэрэгжүүлж ажиллаж байгаа.

Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудсыг 1416 цахим хуудас байдаг бол энийг ер нь иргэд тэр болгон төрийн байгууллагын цахим хуудсыг олж таньж, төрийн үйлчилгээ, өөрсдийнх нь гаргаж байгаа мэдээ мэдээллийг авах хүндрэлтэй байдлыг цаашид зогсоож, төрийн gov.mn системийг нэвтрүүлсэн.

Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудас нэвтэрснээрээ цаашид 1 цонхоор мэдээллийг авдаг, 1 стандартаар иргэдэд хялбар ойлгомжтой болдог, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзэх, харах, нэвтрэх боломжийг олгосон нэгдсэн системийг нэвтрүүлсэн. Одоогоор бусад төрийн байгууллагууд цахим хуудсаа хаах чиглэлээр, зарим архивын бичиг баримтуудыг олон жилийн хур архивын бичиг баримтуудаа хуулбарлаж авах зэрэг процессууд явагдаж байгаа.

Салбар хоорондын цахим шилжилтийн нэгдсэн удирдлагаар хангах хүрээнд дараагийн асуудал нь Монгол Улсын суурь мэдээллийн сантай холбоотой асуудал хөндөгдөнө.

Суурь мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр Улсын бүртгэлийн ерөнхий газартай 14 чиглэлд хамтран ажиллах чиглэлээр харилцан тохиролцон ажиллаж байна. Улсын бүртгэлийн үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлэх, блокчэйн технологи нэвтрүүлэх, суурь мэдээллийн сангийн нөөцийг Үндэсний дата төвд байршуулах асуудал, хурдан болон дөт киоск машины үйл ажиллагааг нэгтгэх асуудал, улсын хэмжээний байгалийн гамшиг үзэгдэл, осол аваар, нийтийг хамарсан гамшгийн үед иргэд, хуулийн этгээд, бүртгэлийн үйлчилгээг хөдөлгөөнт хэлбэрээр хүргэх чиглэлээр бас байгууллага хоорондын хамтын ажиллагаа идэвхжиж ажиллаж байгаа.

Байнгын хорооны даргын сая яриан дээр дурдагдсан программ хангамжийн тоо судалгааны мэдээллийг бид нар бас бүх төрийн байгууллага, төрийн өмчит компаниуд, холбогдох олон улсын байгууллагуудаас хийсэн мэдээллийг Сангийн яам холбогдох мэдээлэл агуулж байгаа байгууллагуудтай хамтарч нэгтгэсэн. Бүх аймгийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Тамгын газар, Боловсролын яам, Эрүүл мэндийн яам гэх мэтчилэн 27 байгууллагыг дарааллаар нь тогтоосон.

Ашиглагдахгүй байгаа маш олон системүүд мэдээж байна. Ашиглаж байгаа 13526 нийлбэр дүнгээрээ бүх төрийн байгууллагууд дээр ийм программ хангамж байна гэсэн судалгааг бид нар авсан байна. 2024 оны элэгдэл тооцоогүй дүнгээр мөн тоон мэдээллийн статистик нэгтгэсэн байж байгаа. 269 тэрбум 600 сая орчим төгрөгийн санхүүгийн тайланд тусгасан программ хангамжийн дүн байна гэсэн нөгөө өмнө дурдсан тоон дээр ийм тоон мэдээлэл, статистик нэгтгэгдсэн. Энийг байгууллага болгоноор нь жишээ нь Боловсролын яам гэхэд улсын төсвөөс 6

тэрбум 880 сая, өөрийн хөрөнгөөр 4 тэрбум 500 сая, балансаас шилжсэн 96, орон нутгаас шилжсэн гэх мэтчилэн байдлаар хандив тусламжаар 886 сая гэх мэтчилэн тус бүрд нь байгууллагаар нь энэ судалгаагаа эцэслэж гаргасан байгаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бас хийгдсэн төсөл байгаа. 22 төсөл 2012-2024 онд 94,2 тэрбум төгрөгийн төсөл хэрэгжсэн гэж үзэж байгаа. Үүнээс 9,8 тэрбум төгрөг 2025 онд бол 2 төсөл хэрэгжиж байгаа гэж байгаа боловч энэ бол төсөл гэдэг нь Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд гэдэг юм уу ингээд тухайн төслийг нь дотор нь яг софтвер, хардвэрийн түвшинд бас ялгахад одоогоор бол бид нарт нээлттэй мэдээлэл нь эцэслэгдэж ирээгүй байгаа. Гадаадын зээл тусламжийн санхүүжилтээр 38,9 сая доллар, үүнээс 2015-2024 оны хооронд 22 төсөл хэрэгжүүлсэн байна. 187 сая долларыг 2025 онд 8 төсөл дээр хэрэгжүүлэхээр Сангийн яамнаас судалгаа мэдээллийг бидэнд ирүүлсэн байгаа.

Дараагийн бүлэгт кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ мэдээллийн аюулгүй байдлын аудит хийсэн талаарх мэдээллийг бас хүргэе.

Эрсдэлийн үнэлгээ аудит хийлгэх үүрэг бүхий байгууллагуудыг Засгийн газрын тогтоолоор баталж өгсөн байдаг. Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон байгууллага буюу Засгийн газрын 2022 оны 197 дугаар тогтоолоор 166 байгууллагад холбогдох эрх олгосон байдаг. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага буюу Засгийн газрын 2022 оны мөн тогтоолоор 216 байгууллагыг одоогоор онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагаар Засгийн газрын тогтоолоор баталж өгсөн байдаг. Эрсдэлийн үнэлгээ, аудит хийх байгууллага дээр мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрөл бүхий зөвшөөрөл авсан 40 байгууллага байна. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх зөвшөөрөл бүхий 26 байгууллага зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа.

Тагнуулын байгууллагын болоод Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас гаргасан тоон мэдээллээр бол 364 байгууллагын 88 хувь нь бол тодорхой эрсдэлийн түвшинд байна. Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон буюу онц чухал дэд бүтэцтэй байгууллагуудын 84 хувь нь эрсдэлтэй түвшинд байна гэсэн бас мэдээлэл статистик гарсан. Улсын Их Хурал болоод Засгийн газрын харьяа байгууллагуудын 54 хувь нь тодорхой түвшний эрсдэлтэй байна гэсэн мэдээллүүд байгаа.

Нэмэлт мэдээлэл өгөхөд 2024 оны жилийн эцсийн байдлаар төрийн байгууллагууд руу чиглэсэн сүлжээний сэжигтэй хандалтууд бас улс орон даяар ирдэг. Гадаадын улсуудаас. Жишээ нь 2 улсын жишээ улсын нэр дурдахгүй дурдахад 1 улсаас гэхэд 128 сая удаагийн халдлага хийх, нөгөө нэг улсаас бол 50 сая орчим удаагийн ийм халдлага хийх орлогууд бүртгэгдсэн гэсэн тоон мэдээллүүд байна.

Ингээд байнгын хорооны дарга, гишүүдэд анхаарлаа хандуулсанд баярлалаа. Тэгээд асуултад хариулахад бэлэн байна.

Ж.Золжаргал: Асуулт эхлэхээс өмнө таны мэдээлэл дээр би түрүүлээд 1, 2 юм асуучихъя. Улсын Их Хурлын 52 дугаар тогтоол 1 дүгээр улиралд багтааж Их хуралд танилцуулах ийм агуулгатай тогтоол байгаа. Тэгээд тайланг гаргаж танилцуулах. Тэгэхээр тайлан одоо бол явцын мэдээлэл гэж та бүхнээс авсан. Тэгэхээр энэ нөгөө хугацаандаа танилцуулагдаж амжихгүй байгаа гол хүндрэл нь

юу байна. Мэдээлэл цуглаж өгөхгүй байна уу, эсвэл ямар шалтгаан байна. 1 ийм асуулт. 5 номерын микрофон.

П.Алтан-Од: Миний илтгэл дээр дурдагдсан 2025 оны байдлаар тоон мэдээлэл статистикийг Монгол Улс ер нь өөрөө ингээд хэдэн системтэй гэдгээ нэгдсэн байдлаар тоолоогүй. Хэдэн төгрөгийн систем, программ хангамжийг хэдэн төгрөгөөр худалдаж авсан юм бэ гэдэг тоон мэдээлэл одоогоор аль ч байгууллага дээр нэгтгэгдээгүй байсан. Яам дээр өгөгдсөн үүргийн дагуу энэ мэдээллүүдийг нэгтгэж, Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны агентлаг зэрэг холбогдох бүх байгууллагуудаас судалгаа авсан. Төрийн байгууллагууд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрууд, яамнуудаас мэдээлэл авсан. Ингээд судалгааны дүнгээ нэгтгээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Ер нь бол байгууллагууд яг программ хангамж, софтверийн мэдээллүүдийг бас цаашид баланс дээрээ тусгасан бодит үнийн дүнгээр явахгүй бол маш олон зөрүүтэй мэдээллүүд бол Их Хурал, Засгийн газар, олон нийтийн байгууллагуудаар хэлэлцэгдээд яваад байсан учраас яг сүүлийн байдлаар нэгд гэсэн судалгааны тайланг танилцуулж байгаа. Энэ цаашдаа бас нөгөө байнгын хөдөлгөөнүүд орно. Энэ онд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд, өнгөрсөн оных нь балансаас хасагдах дүнгүүд гээд хөдөлгөөнүүд ороод явах учраас жил тутамдаа давтамжтайгаар ямар ч байсан судалгаануудыг гаргаж хүргүүлээд байх болно.

Ж.Золжаргал: Ийм зүйл хэлмээр байгаа юм. Энэ Улсын Их Хурлын 52 дугаар тогтоол бол төсөв дээр гаргасан Их Хурлын гишүүдийн ажлын хэсгээс гарсан дүгнэлтэд үндэслээд, Их Хурлаас гарсан. 2025 оны 1 дүгээр улиралд тайлан гаргаж танилцуулах үүрэгтэй. Тэгээд хийгдээгүй байгаа. Юу болж байна гэж араас нь шаардсаны үндсэн дээр мэдээлэл ирүүлсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас.

2 дугаарт нь Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан 3 тогтоол байна. 2025 оны 1 дүгээр сарын 14-ний 2 дугаар тогтоол. 29 дүгээр заалт. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр заалт буюу энэ цахим системүүд хэрэгтэй юу, хэрэггүй юу, давхацсан уу, үр ашигтай юу гэдэг дээр яамнаас зөвлөмж авах ёстой боловч тэр нь хэрэгждэггүй болох нь өнгөрсөн жил бол илэрхий болсон. Тийм болохоор та бүхэнтэйгээ ярилцаад энийг ер нь хэрэгжүүлдэг болгоё гээд тогтоол бичээд явуулсан. Тэгэхээр энэ жилийн төсвөөс санхүүжүүлж байгаа төслүүд дээр энэ зөвлөмжөө авч байгаа юу гэдэг дээр хариулт өгнө үү.

2 дугаарт нь 2025 оны 1 дүгээр сарын 14-ний Байнгын хорооны 1 дүгээр тогтоол. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой. Энэ болохоор улсын төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар нийтэд танилцуулах хуулийн заалттай. Тэгээд маш олон веб сайтууд байдаг. Хүнд ойлгомжгүй байдаг. Энийг нэгтгэх шаардлагатай гэдэг агуулгаар тогтоол гарсан. Энэ дээр бол Сангийн яам бас түлхүү ажиллаж байгаа байх. Тэгээд энэ тогтоолын хэрэгжилтийг бид бас хүлээж байгаа. Энэ дээр хэрвээ мэдээлэл байвал одоо өгч болно. Байхгүй бол дараа өгч болно.

Гуравдугаарх нь мэдээллийн технологийн тоног төхөөрөмжүүд болон кибер аюулгүй байдлын эдийн засгийн ангиллын улсын төсөвт шинээр нэмэх тухай тогтоол гаргасан. Тэгэхээр энэ маань хэзээ нэмэгдэж орж ирээд хэзээнээс төсөв

дээр бид нар яг мэдээллийн технологид энийг нь зарцуулж байгаа, кибер аюулгүй байдалд тэрийг нь зарцуулж байгаа гэдгийг мэдэх вэ. Ийм 3 зүйл дээр та бүхэнд тодорхой хариулт байвал өгмөөр байна.

Ерөнхий асуулт нь бол Улсын Их Хурлаас гаргаж байгаа тогтоол болон Улсын Их Хурлын Байнгын хорооноос гаргаж байгаа тогтоол хэрэгждэг байх ёстой. Тогтоол нь утгагүй тогтоол юм байна. Эсвэл ингээд хэрэгжих боломжгүй гэдэг зүйл байвал хариулт ирж байх ёстой. Тэгээд хариултын цаг хугацааг нь бас харж ажиллахыг бид бас шаардах ёстой юм байгаа юм. Тэгэхээр энэ Улсын Их Хурлын 52 дугаар тогтоол ер нь хэзээ тайлан нь гараад Их Хурал дээр ирж танилцуулагдах вэ. Ийм асуулт байна. Тэгээд асуултуудаа авъя. 5 номер Алтан-Од дарга.

П.Алтан-Од: Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Нийтийн мэдээллийн мэдээлэл хариуцагч, тус хуулийн мэдээлэл хариуцагч 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт мэдээлэл хариуцагч нь хуулийн 29.4-д зааснаас бусад нийтийн мэдээлэл систем үүсгэхийн өмнө дараах асуудлаар цахим хөгжил, инновац, харилцаа холбооны захиргааны төв байгууллагаас зөвлөмж, дүгнэлт гаргуулахаар зохицуулсан байдаг. Ер нь төрийн захиргааны төв байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нар бол бас хангалттай түвшинд өнгөрсөн жил оны сүүлээр бас төсөв дээр тавиулж байгаа. Энэ систем үүсгэхийнхээ өмнө зөвлөмжөө авч байгаа юу гэдэг дээр бас үнэлэлт, дүгнэлт өгсөн. Энэ дээр бол хангалттай биш байна гэж үзэж бид нар төрийн байгууллагууд руу тус хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр бас зөвлөмжүүдийг хүргүүлсэн.

2025 оны байдлаар одоогоор 5 систем үүсгэхийнхээ өмнө манай ESR гэсэн систем үүсгэхихсэн байгаа. Тэр дээрээс зөвлөмж, дүгнэлтээ авах байдлаар ажиллаж байгаа юм байна. Улсын төсвийн цаглаврын хүрээнд 2026 оны төсөв хэлэлцэх цаглавар явж байгаа учраас төсвийн ерөнхийлөн захирагч нар мөн систем үүсгэхийнхээ өмнө зөвлөмжүүдээ авах чиглэлээр ажиллах байх. Манай дээр ажлын хэсэг гаргаж, тухай бүрд нь анализ хийж, зөвлөмжүүдийг нь бол өгч ажиллаж байгаа.

Ж.Золжаргал: 1 дүгээр микрофон Сангийн яам.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ. Золжаргал даргын асуултад хариулъя. Кибер аюулгүй байдалтай холбоотой энэ зардлын ангиллын шинээр бий болгох тогтоол, мөн энэ тогтоолтой холбоотойгоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас ийм ангиллуудыг төсөвт тусгаад ингээд дагаж мөрдөх ийм саналтай байна гэсэн саналыг бол Сангийн яам хүлээж авсан. Улсын Их Хурлын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2024 оны 12 сарын 12-ны 52 дугаар тогтоол, төсөв батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 54 дүгээр тогтоол гээд 2 тогтоолоор бол Засгийн газарт нэлээдгүй олон үүргүүдийг өгсөн байгаа. Эдгээр үүргүүдийн дийлэнх нь ер нь төсөвтэй холбоотой харилцааны асуудлууд учраас Сангийн яаманд бол аягүй олон үүрэг энэ тогтоолуудаар хүлээж авсан байгаа. Бид бол яг.../минут дуусав/

Ж.Золжаргал: 1 дүгээр микрофонд нэмэлт цаг өгье.

П.Бат-Эрдэнэ: Тогтоолуудаар хүлээж авсан энэ үүргүүдээ биелүүлээд ажиллаад явж байгаа. Яг энэ цахим болон энэ кибер аюулгүй байдалтай холбоотой эдийн засгийн ангилал шинээр бий болгох эсвэл арга хэмжээний ангилал ч юм уу. Аль нь зөв байна. Энийг бол судлаад явж байгаа. Тэгээд бидний төлөвлөж байгаагаар бол 2026 оны төсвийг Их Хуралд өргөн мэдүүлэхдээ яг энэ шинэчилсэн ангиллын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдаасаа төсвийн төслийг нь хүлээж аваад, энэ дагуу бас төсвийн төслөө Их Хуралд өргөн мэдүүлэх ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа.

Ж.Золжаргал: Нөгөө 52 дугаар тогтоолын 4 дүгээр заалтын биелэлт тайланг Улсын Их Хуралд хэзээ өргөн барих вэ. Энэ тал дээр мэдээлэл байна уу. 5 номер:

П.Алтан-Од: Тус тогтоол Ерөнхий сайдад даалгасан байдаг. Тэгээд тогтоолын хэрэгжилтийн тайлангаа бол бид нар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар луу хүргүүлсэн. Хэрэг эрхлэх газраасаа Их Хурлын Тамгын газар луу шууд хүргэгдэх бай. Бид нар Хэрэг эрхлэх газар луугаа хүргүүлсэн байгаа.

Ж.Золжаргал: Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Пунсалмаа гишүүнээр тасаллаа. Анар гишүүн асуулт асууна.

Ч.Анар: Өдрийн мэнд. 2 зүйл тодруулах гэсэн юм. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2012-2024 онд 22 төсөл 94,2 тэрбум гэж байх юм. Энэ нь миний санаж байгаагаар 2022 он, 2023 онд Учрал сайд Цахимын яамны сайд байхдаа шал өөр тоо танилцуулж байсан. Логикоор бодоод үзэхээр ч гэсэн 94,2 тэрбум баймааргүй юм. Энэ тоо алдчихсан уу, эсвэл та хэд бүртгэл дээрээ өөр аргачлал ашиглав уу. Энийг тодруулах гэсэн юм.

2 дугаарт нь 2025 онд 187,8 сая долларын гадаадын зээл тусламжийн санхүүжилтээр 8 төсөл гэж байна. Энэ ямар төслүүд юм бэ. Эсвэл хэрэгжихээр орж ирж байгаа юм уу. Энэ том үнийн дүнтэй төслүүд нь юу юм бол. Программ хангамж гэдэг энэ 2 талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас асууя.

Ж.Золжаргал: Та бүхэн хариулахдаа энэ юуг гаргах арга байна уу. Тэр нөгөө 270 тэрбум, 94 тэрбум энэ тэр гэсэн тоог. Ингэж байгаад тэр тоогоо гаргаж байгаад хариултаа өгье. Тийм ээ. Алтан-Од дарга уу. 5 дугаар микрофон нээж өгнө үү.

П.Алтан-Од: Анар гишүүний асуултад хариулъя. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар зөвхөн программ хангамжийн асуудлыг нь бид нар судалсан. Тоног төхөөрөмжийн асуудлыг нь гэвэл мэдээж энэ бас үлэмж тоонууд явж байгаа.

2012-2024 онд 22 төсөл хөтөлбөр хэрэгжсэний 94,2 тэрбум төгрөг гэж байгаа юм. Зөвхөн энэ программ хангамжийн асуудал дээр. Гадаадын зээл тусламжаар санхүүжилтээр хэрэгжих 187,8 сая долларын төслийг 2025 онд хэрэгжүүлэхээр заасан байгаа. Энэ дээр Сангийн яамнаас авсан мэдээллээр харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах чиглэлээр төсөл байна.

Монгол, Энэтхэгийн хамтарсан мэдээлэл технологийн автосорсингийн төв байгуулах төсөл. Архивын ерөнхий газрын цогцолбор, барилгын тоног төхөөрөмж техник хэрэгслийн хангамжийн төсөл, Тогтвортой амьжиргаа 3 төсөл, Төлбөрийн

системийн шинэчлэл төсөл, Төсвийн санхүүжилтийн удирдлага, ил тод, үр ашигтай байдлын төсөл. Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл гэсэн энэ төслүүд дээр бол нийтдээ 187,8 сая долларын асуудал тусгагдсан байгаа. Энэ мэдээж дотроо зөвхөн нөгөө программ хангамж биш маш олон төслүүдийн арга хэмжээнүүдийн нийлбэр дүнгээрээ багцлагдсан мэдээлэл байгаа.

Шаардлагатай бол Сангийн яамнаас мэдээлэл нэмээд өгчих боломжтой байх.

Ж.Золжаргал: Анар гишүүн тодруулна.

Ч.Анар: Энэ зөвхөн программ хангамж гээд 94,2 тэрбум байх ёсгүй. Энэ хамаагүй том тоо байх ёстой. Тэгэхээр энэ тооцоо судалгаа чинь жоохон худлаа байна. Энийгээ дахиад тодруулаад албан бичгээр Байнгын хороонд ирүүлэхийг хүсье. Баярлалаа.

Ж.Золжаргал: Би Анар гишүүний асуусан асуулт дээр тодруулаад бас асуучихъя. Энэ саяын асууж байгаа тоонууд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Учрал сайдын гарын үсэгтэй албан бичиг болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Баатархүү сайдын гарын үсэгтэй 2 бичиг бол яг адилхан агуулгатай ирсэн. Хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн 269,6 тэрбум төгрөгийн үнэ бүхий 13526 программ гэж байгаа. 269 тэрбум. Тэгээд доор нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2012-2024 онд 94 тэрбум төгрөгийн 22 төсөл хэрэгжсэн. 2025 онд 9,8 тэрбум төгрөгийн 2 төсөл хэрэгжсэн. Гадаадын зээл тусламжаар 2015-2024 онд 38,9 сая долларын 2 төсөл, 2025 онд 187,8 сая долларын 8 төсөл тус тус хэрэгжиж байна гээд. Тэгэхээр энэ 270 тэрбум төгрөг чинь хөрөнгийн бүртгэлд байгаа, бүртгэгдсэн үнэлгээний нийлбэр дүн гэсэн үг үү. Нөгөө доор байгаа тэр 2012-2024 оны 94 тэрбум төгрөг, 2025 оны 9 тэрбум. Тэгээд гадаадын зээл тусламжийн 39, 188 сая долларын төслүүд бол энэ 269 тэрбум дотроо ороогүй. Тусдаа гэсэн үг юм уу. Энэ тоонуудын хоорондын уялдааг нэг тайлбарлаад өгөөч. Энийг сайн ойлгохгүй байгаад байгаа юм. 5 дугаар микрофон.

П.Алтан-Од: Манайхан дэлгэц рүү бас тэр программ хангамж судалгаа сая төгрөгөөр гэснийг дэлгэц дээрээ слайдыг өгчхөөрэй. Ерөнхийдөө 27 байгууллагаас ирүүлсэн улсын төсвөөс өөрийн хөрөнгөөр баланст шилжсэн орон нутгаас шилжсэн, хандив тусламж, гаднын хөрөнгө оруулалт гээд бүх тоо мэдээллүүдийг нь бүртгэлээр нь авсан байгаа.

2024 оны санхүүгийн жилийн эцсийн байдлаар санхүүгийн тайланд тусгагдсан 269,6 тэрбум төгрөгийн программ хангамжийн асуудал байдаг. Энэ дээр бол элэгдлийг хасаагүй дүнгээр байгаа. Хойд талын 94,2 тэрбумтай гэдэг нь 22 төсөл хөтөлбөр хэрэгжсэн. 2012-2024 онд гэж байгаа. Тэр дотор жишээ нь цахим эрүүл мэнд гэдэг төсөл байлаа гэхэд дотор нь зөвхөн программ хангамж биш тоног төхөөрөмж маш олон төслүүдийн төсөл доторх энэ хөрөнгө оруулалтуудын шинжтэй зардлууд байдаг учраас энийг нь бол төсөл болгоноор нь ялгаж ангилахад мэдээж цаг хугацаа орох байх. Тэр мэдээлэл бол манай яам дээр бол байхгүй. Зөвхөн программ хангамж бүхий мэдээллүүдийг эргүүлж нэгтгэхийг хүссэн энэ судалгааны дүнгээ би та бүхэнд бас ялгаж танилцуулж байгаа нь энэ юм.

Ж.Золжаргал: Гадаадын зээл, тусламж болон төсвийн юугаар хэрэгжсэн төслүүд гээд энэ өгсөн мэдээллийг нэмээд үзэхээр 913,9 тэрбум төгрөг нийлбэр

дүн нь. Тэгээд цаана нь дахиад 269,6 тэрбум төгрөгийн хөрөнгийн бүртгэл. Тэгэхээр энэ 913 тэрбум төгрөгийн нийлбэр төсвөөр хийсэн ажлын үр дүнд гарсан хөрөнгийн бүртгэл нь 269 тэрбум гэсэн үг мөн үү. Эсвэл энэ 913 дээрээ 269-г нэмэх юм уу. 5 номер.

П.Алтан-Од: Энэ гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлэх гэдэг дүнтэй ажил нь бол сая би нөгөө 8 ажил гэсэн. Энэ хэрэгжилтийнхээ шатанд явж байгаа учраас өнгөрсөн жилийн 269 гэдэг дүн дээр бол нэгтгэгдэхгүй. Нэгтгэгдэхгүй гэсэн үг. Тэгээд доторх ангиллынх нь харах юм бол мэдээж нөгөө удаа дараа хэлж байгаа. Олон төрлийн зардлууд байж байгаа. Тэгээд программ хангамжийг нь ялгаж ангилах одоогоор бол бид нар дээр тийм дата мэдээлэл байхгүй. Гадаадын зээл зээл тусламжаар цахим шилжилттэй холбоотой 2025 онд хэрэгжүүлэх төсөл гэдэг дүн дээр 187,8 сая доллар гээд тавьчихсан байж байгаа. Тэгэхээр энэ слайд дээр үзүүлж байгаа байгууллага болгоноор нь гаргасан балансын бүртгэлтэй хөрөнгөтэй байгаа мэдээллүүдийг бид нар яг бодит мэдээлэл гэж үзнэ. Тэгэхээр энэ мэдээллүүдийг бол нэгтгэсэн дүнгээ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар луу болоод Байнгын хорооны гишүүд рүү Байнгын хорооны ажлын албаар дамжуулаад хүргүүлчихсэн байж байгаа. Тэгээд холбогдох нэмэлт мэдээлэл байвал Сангийн яамныхан маань бас мэдээлэл хийж бас болох юм шүү.

Ж.Золжаргал: Яг үүнтэй холбоотой дахиад тодруулчихъя. Энэ 2024 он хүртэл, дараа нь 2025 оны дүн дээр бүгдийг нь нийлүүлэхээр гадаад зээл тусламжийг одоо явж байгааг нэмэхээр 913 тэрбум гээд. Тэгээд энэ дотор болохоор хууль хүчний байгууллагууд, батлан хамгаалах салбар, хамгийн гол нь нийслэлийн Засаг даргын Тамгын газартай холбоотой цахим системүүдийн хүснэгт дотор ерөөсөө олж харагдаагүй. Байхгүй. Тэгээд төрийн өмчийн компаниуд төрийн өмчийн компаниуд чинь бүгдээрээ тус тусдаа бас худалдан авалтууд хийж байгаа цахим системүүд. Энэ дүнгүүд бол ороогүй гэж ойлгож байна. Мөн үү. Энэ дээр баталгаажуулчихмаар байна. Хэрвээ эд нар орох юм бол энэ ингээд ойролцоогоор 1 их наяд байна гэхэд тэд нар бол тусдаа. Хэрвээ бүгдийг нь нэмэх юм бол энэ дээр нэмэгдэнэ гэж ойлгож байна. Зөв үү. Тэр нийслэлийн мэдээлэл нь яагаад ирэхгүй байгаа юм бол. Лавлаж асууж үзсэн үү. Энэ тал дээр хариулт. Хариулах уу. Бэлдэж байх хооронд нь Анар гишүүн нэмэлт асуулт асуучихъя. Анар гишүүний микрофоныг нээж өгнө үү.

Ч.Анар: Энэ 2023 онд Учрал сайд мэдээлэл хийсэн байна л даа. Бас 2023 оны 6 сарын 21-нд. Төр жилд 950 тэрбумыг программ хангамжид худалдан авахад зарцуулдаг гээд. Би бас тэрний өмнө тооцоолол харж байсан. 2012-2020 онд 900 хэдэн тэрбум гэж байх ёстой. Тэгэхээр энэ тоонууд зөрөөд байна. Тэгэхээр цахим яам дээр яг бүртгэгдэх ёстой. Тэгээд энэ 94 тэрбум бол яав ч биш. Тэгэхээр аль нь зөв мэдээлэл вэ.

Ж.Золжаргал: Саяын юун дээр тодруулга хариултуудыг өгье. 5 дугаар микрофон.

П.Алтан-Од: Гишүүний асуултад хариулъя. Энэ Засаг даргын Тамгын газар гэсэн слайд дээр байгаа мэдээлэл дээр бол бүх аймаг, дүүрэг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн мэдээлэл гэж ойлгож болно. Батлан хамгаалахын чиглэлийн бол 24 дүгээр дэс дээр нь байж байгаа. Батлан хамгаалахын яамны баланс дээр бүртгүүлсэн гэж байгаа. Мэдээж нууцын

зэрэглэлтэй юу нь бол мэдээж энэ бүртгэл дээр бол орж ирэх боломжгүй байх. Ер нь төрийн захиргааны болоод захиргааны байгууллагуудын бүх мэдээллүүдийг нэгтгэсэн, баланс дээр бүртгэсэн гэдэг мэдээлэл явж байгаа. Тэгээд бүртгээгүй мэдээлэл бол нэгтгэгдэж ирэх ийм бас боломжгүй байх гэж бодож байна. Өмнө нь хийгдсэн Учрал сайдын хийсэн мэдээлэл дээр бол нөгөө олон улсын төсөл хөтөлбөрүүдээс хэрэгжиж байгаа жишээ нь Ухаалаг засаг ч гэдэг юм уу, Дэлхийн банкны холбогдох олон улсын байгууллагуудын мэдээллүүдийнх нь нийлбэр дүнг нь бодох юм бол тэр лүү дөхнө. Тэр дотор мэдээж хүний нөөцийг бэлтгэх, программ .../минут дуусав/

Ж.Золжаргал: 5 дугаар микрофон нэмэлт. Төрийн болон орон нутгийн өмчийн компаниудын талаар ер нь ямар нэгэн бүртгэл байдаг уу та бүхэн дээр. 5 дугаар микрофон нэмэлт цаг өгье.

П.Алтан-Од: Энийг Төрийн худалдан авах ажиллагааны газраас бол холбогдох мэдээллүүдийг авсан. Тэгээд төрийн өмчит компаниудын мэдээллүүдийг бол энэ тоон мэдээлэл дээр нэгдсэн байдлаар мэдээлээд явчихсан байж байгаа. Сангийн яамнаас биш, Төрийн худалдан авах ажиллагааны газар дээр байсан мэдээллийг гэсэн үг.

Ж.Золжаргал: Пунсалмаа гишүүн асуулт асууна.

Б.Пунсалмаа: Та бүгдэд өдрийн мэнд хүргэе. Надад 3 асуулт байна. Салбар хоорондын цахимжилтын явц, систем хоорондын уялдааг сайжруулах талаар хийж хэрэгжүүлж байгаа ямар арга хэмжээнүүд байна. Шийдэл нь юу байна.

2 дугаарт нь болохлоор улсын хэмжээнд нийт 13526 программ хангамжийг хэрхэн нэгтгэх вэ. Суурь мэдээллийн сантай холбогдож чадаж байгаа юу гээд 2 дугаар асуулт байна.

3 дугаарт нь болохоор төрийн мэдээлэл ер нь иргэддээ хэр хүрч байгаа юм. Өнөөдөр бол 21 аймаг, 330 сум, 1575 одоо багуудаас нэлээд олон багууд өнөөдөр интернэтэд холбогдож чадахгүй. Уулан дээрээ очиж утсаар ярьж, сум нэгдэлд очиж байж интернэтэд холбогдож байгаа. Ийм цаг үед бол Төрийн мэдээлэл бол иргэдэд хэр бүрэн дүүрэн очих вэ гэдэг асуулт. Өнөөдөр энэ асуудлыг шийдээрэй гээд Монгол Улсын төсвөөс энэ жил бол Увс аймгийн Улаангом сум, Сагил сум Тариалан, Хэнтий аймгийн Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Өндөр, Дадал, Дархан, Баянмөнх сумууд, Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган, Галт, Түмэн, Жаргалант, Баянзүрх сумуудад энэ үүрэн холбоо, цахим холболтын станцуудыг бариарай. Дамжуулах станцуудыг сайжруулаарай гээд 22 тэрбум төгрөг тавьж өгсөн байгаа. Энэ ажлын явц хэр явагдаж байна. Ямар компаниуд гүйцэтгэж байгаа юм. Ерөөсөө бид нар ажлын явцыг ер нь дандаа цаасан дээр тайлан тавиад орхих юм. Энэ удаа бол бид нар үнэхээр бодит энэ сумуудыг интернэт үүрэн холбоонд холбох хэрэгтэй байна. Энэ ажлын явц ямар байгаа вэ. Сонсьё.

Ж.Золжаргал: Алтан-Од дарга 5 дугаар микрофон.

П.Алтан-Од: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Гишүүн төрийн үйлчилгээ цахимаар авахад иргэдэд тулгарч байгаа асуудал, ер нь ямар хүндрэл бэрхшээл байгаа юм. Одоо тоо статистик мэдээллийн талаар бас уулзахаараа мэдээлэл юунуудыг бас биднээс авч ажилдаг. Ажил хэрэгч түвшинд манай

салбарын асуудал дээр анхаарлаа хандуулж ажилладаг гишүүдийн нэг. И-монголиагаар бол 87 үйлчилгээ үзүүлэгч байгууллагын 1263 үйлчилгээг бол иргэд авах боломжтой байгаа. И-бизнесээр бол 68 байгууллагын 832 үйлчилгээг бол авч байгаа. Лавлагаа Оператор Монголиа, Киоск И-Монголиа, Мобайл аппликэйшн зэрэг төрийн үйлчилгээг цахимаар авах боломжтой маш олон энэ сувгуудыг бол бий болгосон. Төр өөрт байгаа мэдээллийг иргэдээс шаардахгүй байх үүднээс бол төрийн үйлчилгээг цахимжуулах чиглэлээр нэлээн бас дорвитой ажлууд хийгдсэн. Үүний үр дүнг бол иргэд хүртэж байгаа. Төрийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо мэдээж багасаж байгаа. Төрд бүтээмжийн асуудал нэмэгдэж байгаа. Цахим шилжилттэй холбоотойгоор 2019-2024 оны хооронд 79 сая үйлчилгээг төрийн цахим хэлбэрээр хүргэсэн байдаг. Цаашид бас энэ И-Монголиа дээр оруулсан төрийн үйлчилгээг цахимжуулахтай холбоотой төрөөс энэ үйлчилгээг үзүүлэх шаардлагагүй гэсэн үйлчилгээнүүдийг нь И-Монголиагаар авахгүй байгаа үйлчилгээнүүдийн тоон мэдээлэл статистикийг бас бид нар нэгтгэж авсан байгаа.

Цахим хэлбэрт шилжүүлснээр нийт 52 байгууллагын 527 буюу 41,3 хувийн үйлчилгээг бас иргэд тэр болгон авахгүй, авах шаардлагагүй үйлчилгээ байна гэсэн мэдээллүүд байж байгаа учраас төрийн үйлчилгээний дахин инженерчлэлийн асуудал дээр бид нар Анар гишүүний ахалсан ажлын хэсэг дээр тодорхой бас цахим талаасаа бид нар мэдээллүүдийг бол хүргүүлж ажиллаж байгаа.

2 дахь асуулт дээр дурдаж байгаа харилцаа холбооны бааз станцууд ер нь хүртээмжийн асуудал дээр гишүүн асуулт асууж байна. Увсын Бөх мөрөн, Өмнөговь, Баруунтуруун зэрэг багцуудын асуудлыг хөндөж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсөв дээр тавигдсан. Тендер сонгон шалгаруулалтууд нь зохион байгуулагдаад гэрээ нь байгуулагдсан. Ажлууд нь амжилттай хэрэгжээд явж байгаа. Энэ ондоо бүрэн хэрэгжээд хүлээлгэж өгөх талаар зохион байгуулж ажиллаж байна. Мөн Увсын Улаангом, Сагил сум, Тариалан сумын ажлууд дээр гэрээ байгуулагдсан. Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дадал, Дархан, Баянмөнх зэрэг Хэнтий аймгийн ажлуудыг бол Хэнтий аймгийн Засаг даргад эрх шилжүүлснээр тухайн аймаг нь зохион байгуулаад тендер нь зохион байгуулагдаж, гэрээ нь хэрэгжих шатандаа ажиллаж байгаа юм байна. Хөвсгөлийн Эрдэнэбулган, Галт, Түнэл, Жаргалант, Баянзүрх сумууд дээр зохион байгуулагдсан ажил бол одоо гэрээ байгуулагдсан. Ажил нь явж байгаа. Ер нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Монгол Улсын бүх суманд үйлчилгээ орсон. Зарим багийн төвүүдийг үйлчилгээнд холбох ажлууд бол улсын төсвийн хөрөнгө оруулалт болоод бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн зохион байгуулалтаар явж байдаг. Үүргийн сангийн хөрөнгийг төвлөрүүлэх нь бол хувийн хэвшил буюу тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд бол орлогоо төвлөрүүлдэг боловч улсын төсөв батлагдахад бол энэ жил тал дүнгээрээ батлагдсан учраас бүх зайлшгүй шаардлагатай боомт дээр гэдэг юм уу багийн төвүүд дээр үйлчилгээ оруулахад мэдээж төсвөөс хамааралтайгаар ингээд бас асуудлууд үүсэж байгаа. Цаашид бас бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн онцлогт тохируулаад үүргийн сан дээр төвлөрүүлсэн тухайн оператор компаниуд, тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудын хөрөнгийг нь шууд 100 хувь тавьж өгч, алслагдсан дэд бүтэц шаардлагатай хэсгүүдэд үйлчилгээг хүргэх тал дээр бас ажиллах ийм зайлшгүй шаардлага байгаа талаар оролцогч байгууллагуудаас хүсэлт, гомдлууд удаа дараа бас ирж байдаг.

Дараагийн асуудал дээр манай хэлтсийн дарга Батбаяр дарга нэмэлтээр хариулт өгчихнө.

Ж.Золжаргал: Батбаяр дарга 6 дугаар микрофон.

Д.Батбаяр: Системүүдийн уялдаа холбоог хангах чиглэлээр ямар ажил хийгдэж байгаа вэ гэсэн гишүүний асуултад дэлгэрэнгүй хариулъя. Ер нь системүүдийн хоорондын уялдаа холбоог хангахдаа бид нар Хур систем төрийн мэдээ солилцооны үндсэн систем буюу Хур системийг ашиглаж, мэдээлэл солилцож байгаа. Энэ систем маань өөрөө хуульчлагдсан систем гэж та бүхэн бас мэдэж байгаа байх. Тэгээд нийт систем бол төрийн 171 байгууллага, хувийн хэвшлийн 462 байгууллага гэрээлээд хоорондоо мэдээллээ солилцож байгаа. Нийт сервисийн тоо болохоор 845 гэж хамгийн сүүлийн мэдээллээр. Тэгээд эндээсээ бид нар дамжуулсан, хамгийн амжилттай дуудсан сервис бол 4 тэрбум одоогийн байдлаар болоод явж байгаа гэсэн үг.

Тэгээд хур системийнхээ үндсэн архитектурыг бид нар өөрчлөхөөр энэ жил бас Дэлхийн банкны санхүүжилтийн ухаалаг төс засаг төсөл дээр мөн .../минут дуусав.

Ж.Золжаргал: Гишүүд асуулт асуулаа. Одоо үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. Байхгүй юу. Үг хэлэх гишүүн байхгүй байна.

Ингээд Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл сонслоо.

Ер нь дахиад хэлэхэд Улсын Их Хурлын болон Байнгын хорооны гаргасан тогтоолууд ингээд байхгүй болчихоод байдаг тийм үзэгдэл байдаг юм байна. Тэгээд хэрвээ тогтоол хэрэгжихгүй бол тогтоол гаргаад, хурал хийж цаг зарцуулах хэрэг байхгүй. Бас нэг сонирхолтой юм нь манай энэ салбарын яам уг нь өөрсдөө төрийн цахим систем худалдаж авч байгаа дээр хяналтаа тавиад явах хүсэл сонирхол байдаг. Гэтэл нөгөө хуулийн хэрэгжилт дээр нь салбар салбараас зөвлөмжөө авдаггүй ийм зүйлийг бид нар албан бичгээр асууж байгаад илрүүлсэн гэх юм уу даа тогтоосон шүү дээ. Тэгээд яам дээр энийг ер нь зангидах нь зүйтэй юм байна гэдэг агуулгаар тогтоол гаргаж байсан. Тэгээд тэр ажлуудыг болон энэ Улсын Их Хурлын тогтоолтой холбоотой ажлуудыг Байнгын хорооноос гаргасан тогтоолын талаар бас хэрэгжилтийг нь албан бичгээр дахиж асууя гэж бодож байна. Саяын энэ тоонууд дээр бол яалт ч үгүй л 1 тийм сонин тоонууд харагдаад байгаа юм. Тэгээд тэр шилэн данс дээр бол жишээлбэл нийслэлийн 6 дүүргийн мэдээллүүд байгаад байдаг. Нийслэлийн Тамгын газрын мэдээлэл нь байхгүй. 3 дугаар сарын байдлаар л лав ороогүй байсан. 55,6 хувийн мэдээлэл нь орсон гэсэн ийм тоо байна. Дүүргүүд болоод нийслэлд нийлээд. Тэгээд нийслэл нь болохоор байхгүй байгаад байгаа юм. Энэ тоонууд болон төрийн болон орон нутгийн өмчит компанийн хэрэглэж байгаа цахим системүүдийн худалдан авалтын талаар тоо байна уу. Энэ талаар дахиж магадалж албан байдлаар мэдээлэл хүснэ гэж бодож байна.

Тэгээд 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Эдийн засгийн байнгын хороо болон Төсвийн байнгын хорооныхон анхаарах бас шаардлагатай байгаа. Энэ талаар уламжилна. Ингээд та бүхэндээ мэдээлэл өгсөнд баярлалаа. Хэлэлцэх 2 дугаар асуудал дууссан учраас 3 дугаар асуудалд оръё.

17.03 цаг.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 24 дэх илтгэлийг хэлэлцэнэ.

Ингээд энэ сэдвийн хүрээнд бид бол илтгэлийг бүтнээр нь бүрэн эхээр нь сонсох хувьд товчхон агуулгыг нь сонсоод, гол нь нөгөө цахим технологитой холбоотой асуудлуудыг анхаарч сонсьё гэж байгаа юм. Тийм болохоор танилцуулга хийх хүмүүс маань бас яг тэр заалтууд дээрээ анхаараад товчхон танилцуулж өгнө үү гэж хүсье.

Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 24 дэх илтгэлийг гишүүдэд тараасан байгаа. Ингээд ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Нарантуяа, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул, Хүний эрхийн Үндэсний Комиссын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Тунгалагтамир, Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрхийн боловсролын хэлтсийн ахлах референт Э.Мөнхзул, Хүний эрхийн Үндэсний Комиссын Олон талт хамтын ажиллагааны хэлтсийн референт Л.Мөнхтулга, Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний хувийн мэдээлэл хамгаалах хэлтсийн Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан шинжээч Ө.Энхтөр нар ирсэн байна.

Ингээд танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Мөнхзул танилцуулга хийнэ. Та илтгэлдээ товч хураангуйг нь хэлээд тэгээд цахимтай холбоотой хүчирхийлэл, яг тэрэнтэй холбоотой 2 заалт байгаа. Яг тэрэнтэй нь холбоотой танилцуулгаа хийнэ үү гэж хүсье.

Г.Нарантуяа: Тэгэхээр Мөнхзул гишүүн биш би Нарантуяа байна. Цахим хөгжлийн асуудлаар энэ жилийн хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэлд 2 асуудал орсон байгаа. Цахим технологи ба хүний эрх бүлгийн танилцуулгыг хамгийн гол нь асуудлынхаа нөгөө тавьж байгаа саналынхаа танилцуулгыг би хийгээд, тэгээд жендерт суурилсан хүчирхийлэл, цахим технологитой холбоотой хэсгийн танилцуулгыг Мөнхзул гишүүн хийх юм.

Ж.Золжаргал: Энэ бүртгэсэн дарааллаар эхлээд Мөнхзул, дараа нь Нарантуяа гишүүд хийх юм байна. Тэгэхээр таны бодлоор эсрэгээрээ байх уу. 5 номерын микрофон нээж өгье. Нарантуяа гишүүн танилцуулга хийнэ.

Г.Нарантуяа: Инновац, цахим бодлогын байнгын хорооны гишүүд ээ,

Цахим технологийн хөгжил, харилцаа холбооны хувьсал хийж, мэдлэгийг ардчилж, бүтээмжийг дээшлүүлж, эдийн засгийн хөгжлийг хурдасгаж, хүний амьдралын чанарыг сайжруулахын зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлт, нөөцийн хомсдол нүүрлэж буй өнөөгийн дэлхийд идэвхтэй өсөж буй хүн төрөлхтний аюулгүй, тогтвортой орших шийдэл найдвар болж байна.

Гэвч өгөгдлийг их хэмжээгээр цуглуулж, хадгалж, боловсруулж, ашиглах үндсэн горимоор ажилладаг цахим технологи хүний эрх, эрх чөлөөний ноцтой эрсдэлийг дагуулдаг. Хүний амьдрал бүхэлдээ ямар нэг цахим төхөөрөмжид бүртгэгдэх боломжтой өнөө цаг үед хүний хувийн мэдээлэл, хувийн нууц нь олж авахад харьцангуй хялбар бөгөөд өгөөж хэрэгцээ нь үлэмж их болсныг бид бүгд харж байна.

Хүний хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашигладаг бизнес моделиуд өндөр ашиг олж, хүний хувийн мэдээлэл алдагдах, гэмт хэрэгт ашиглагдах тохиолдол улам бүр нэмэгдэж байна. Мэдээлэл цуглуулж боловсруулдаг энгийн цахим төхөөрөмжийн зэрэгцээ хүнийг тагнах, мөрдөх, хувийн цахим хэрэгсэл дэх мэдээллийг зайнаас татан авах өндөр хүчин чадалтай төхөөрөмжүүд хэрэглээнд нэгэнт нэвтэрчээ. Технологийн хөгжлийг төрийн бодлого эрх зүйн зохицуулалт гүйцэхгүй байгаа нь нийтийн эрх ашиг хохирох эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Хувийн мэдээлэл, хувийн нууц, хувийн орон зай чанд хамгаалагдах нь хүн халдашгүй, эрх чөлөөтэй оршихын үндэс билээ. Дарамт хавчлагаас эмээх айдас хүмүүсийн үзэл бодлоо илэрхийлэх эрмэлзлийг бөхөөж, төрийн үйл хэрэгт оролцох эрхийг хэлбэр төдий болгодог. Хиймэл оюун, цахим технологийн тооцооллын алдаа хүмүүс ялгаварлан гадуурхагдах, хэлмэгдэх нөхцөлийг үүсгэж, алгоритмын ил тод бус байдал нь түүнд хяналт тавих шүүхэд хандах эрхээс сэргийлэх боломжийг хязгаарлах боллоо. Цахим технологийн хөгжлийн үр шимийг зарим хүмүүс эс хүртэж, нийгмийн тэгш бус байдал гүнзгийрч байна.

Технологи уламжлалт хөдөлмөрийг орлох болсны зэрэгцээ цахим платформ технологид суурилсан хөдөлмөрийн шинэ салбар бий болж байгаа нь тэгш бус байдлыг нэмэгдүүлж, хөдөлмөрлөх эрхийн баталгааг сулруулж байна. Цахим технологийн хүний эрхийн эрсдэл өндөр боловч энэ талаарх Монгол Улсын хууль тогтоомж, бодлогын хөгжил эхлэл шатдаа хэрэгжилт хангалтгүй, нэн шаардлагатай хамгаалалт үгүйлэгдэж байгааг Хүний эрхийн Үндэсний Комисс анхааруулж, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын 24 дэх илтгэлд Хүний эрх ба цахим технологиор илтгэсэн билээ.

Илтгэлийн 3 дугаар бүлэг 3 дэд хэсэгтэй. 1 дүгээр дэд хэсэгт Монгол Улсын цахим хөгжлийг тодорхойлох суурь нөхцөлүүд болох бодлого, эрх зүйн орчин, удирдлага, засаглал, цахим технологийн нэвтрэлт, иргэдийн цахим боловсрол, ур чадварын түвшнийг үнэлсэн. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал зэрэг макро түвшний бодлого стратегид цахим технологийг ашиглахад хүний хувийн мэдээллийг хамгаалах асуудал тусгагдсан боловч цахим хөгжлийн салбарын бодлогууд, цахим үйлчилгээг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зэрэг техник, үйлчилгээг сайжруулах асуудалд төвлөрч, цахим технологийн хүний эрхийн эрсдэлийг хянан зохицуулах бодлогыг орхигдуулжээ.

Бодлого тогтворгүй, залгамж холбоогүй, баталсан бодлогын хэрэгжилт хангалтгүй байсан нь цахим хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлсэн Монгол Улсын 20 жилийн туршлагаас анхаарч засах ёстой гол сургамж байна.

Цахим хөгжлийн бодлого хууль тогтоомжид хүний эрхийг хамгаалах бодлого үзэл санаа шингээгүй. Энэ асуудлыг хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулиар зохицуулах дэс асуудал гэж хандсанаас үндэсний цахим дэд бүтцийг бий болгож буй байгууллага албан тушаалтан тухайн технологийн хүний эрхийн эрсдэлийг мэдэхгүй байх, үл тоомсорлох нь түгээмэл байна.

2 дугаар дэд хэсэгт нийтийн орон зайд суурилуулсан камерын ашиглалт, эрх зүйн зохицуулалт, зорчих эрх хязгаарлах ялыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл болох цахим гавын хэрэглээнд анхаарах, хүний эрхийн асуудлууд, тагнах төхөөрөмжийн

эрх зүйн зохицуулалтын хэт ерөнхий үр дүн багатай байдлыг танилцуулсан. Мөн энэ дэд хэсэгт Монгол Улс дахь хиймэл оюуны хөгжүүлэлт, хэрэглээг үнэлж, хиймэл оюуны үндэсний стратегид тусгавал зохих хүний эрхийн зарчмуудыг санал болгохын хамт Монгол Улсад цахим хуваагдал оршин буйг илтгэж ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хөдөөгийн болон орлого багатай айл өрхийг цахим хөгжлөөс үл орхих, цахим хөгжлийн үр шимийг хүртэхэд нь дэмжлэг үзүүлэх шаардлагатай болохыг анхааруулсан.

3 дахь хэсэгт Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулиар мэдээллийн эзний эрх, мэдээлэл хариуцагчийн үүргийг дэлхийн жишигт баталгаажуулсан боловч эрх зөрчигдсөн, үүргээ биелүүлээгүй үед хүлээлгэх хариуцлага албадлагын арга хэмжээг хангалттай хуульчилж чадаагүй. Энэ байдал нь хуулийн хэрэгжилт хангалтгүй, ирээдүйд зохицуулалтын үр нөлөө муу байхыг илтгэж, цахим технологи хүний нийгмийн мөн чанарыг өөрчилж буй энэ цаг үед мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллагыг Монгол Улсад зохих ёсоор бий болгож хөгжүүлэх нь чухал болохыг санууллаа.

Хүний эрх ба цахим технологи илтгэлийг комиссоос 2023-2025 онд 10 салбарын 36 асуудлыг хамруулан явуулж буй хүний эрх ба цахим технологи хяналт шалгалтын эхний үр дүнд суурилан илтгэсэн бөгөөд М-Монголиа систем иргэний бүртгэлийн хүний эрхийн үнэлгээ, эрүүл мэндийн салбарын цахимжилт, олон нийтийн сүлжээг зохицуулах эрх зүйн зохицуулалтын талаар комиссын санал боловсруулах ажлууд үргэлжлүүлэн хийгдэж байна.

Хүний эрх ба цахим технологи илтгэлд хүний эрхийн талаас тулгамдсан цөөнгүй асуудлыг хөндөж тавьсан ч нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн дараах 8 саналыг Улсын Их Хуралд гаргасан.

1.Цахим технологийн хүний эрхийн нөлөөллийг тооцох аргачлалыг цахим хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах, уг аргачлалаар нэн тэргүүнд төрийн үйлчилгээ, үйл ажиллагаанд нэвтрүүлж буй аливаа технологи, систем, платформ, алгоритмыг үнэлэх зохицуулалтыг хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд тусгах, мэдээллийг цуглуулах, боловсруулах горимоор ажилладаг. Цахим технологийг төрийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхдээ эдийн засгийн үр өгөөжөөс гадна, хүний эрхийн эрсдэлийг тооцох, хуулиар тогтоосон шаардлага, хүний эрхийн нөлөөллийг үнэлэх аргачлал байхгүйгээс гарах эрсдэлийг мэдэхгүй байх, алдаа гарахад хүрч байгааг Хүний эрхийн Үндэсний Комиссоос хийсэн автомашины бүртгэлийн цахим хяналт, камержуулалт, цахим гавын ашиглалтад хийсэн үнэлгээ харуулж байна.

Цаашдаа цахим технологийг төрийн үйлчилгээнд өргөн хүрээнд нэвтрүүлэх тул хүний эрхийн эрсдэлийг тооцох шаардлага аргачлалыг бий болгох нь нэн чухал асуудал юм.

2 дахь санал. Хүний хувийн мэдээллийн хуулиар тогтоосон мэдээллийн эзний эрх, мэдээлэл хариуцагч болон мэдээлэл боловсруулагчийн үүргийн зөрчлийг Зөрчлийн тухай хууль, Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд бүрэн тусгаж гэм буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль батлагдсантай холбоотой Эрүүгийн хуульд цөөн тооны нэмэлт, өөрчлөлт орж, хувь хүний нууцыг задруулах зэрэг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг өөрчлөн найруулсан. Гэвч Эрүүгийн хуулийн 13 дугаар

бүлгийн заалтууд Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийг хэрэгжиж эхлэхээс өмнө үйлчилж байсан тул уг хуулийн үзэл санаа хамгаалагдсан хууль ёсны эрх ашгийг гүйцэд тусгаж чадаагүй юм.

Хүний хувийн мэдээлэлд хамаарах гэмт хэрэгт оногдуулах ялыг харьцангуй багаар тогтоосон нь хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах эрүүгийн эрх зүйн үр нөлөөг бууруулж болзошгүй. Хүний хувийн мэдээллийг хууль бусаар өөртөө ашиг олох зорилгоор бусдад дамжуулсан, шилжүүлсэн, худалдсан, гадаад улс руу дамжуулсан, цугларсан, боловсруулсан хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах үүргээ зөрчсөний улмаас хохирол учирсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хуульд тусгах асуудлыг судалж шийдвэрлэх нь зүйтэй.

Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн зохицуулалтад Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулиар тогтоосон мэдээллийн эзний 20 гаруй эрхийн хэрэгжилтийг хангахад хязгаарлагдмал байгаа юм. Шаардлага нийцээгүй зөвшөөрлийн маягтаар зөвшөөрөл авсан, мэдээлэл хариуцагч мэдээллийн эзний хуульд заасан хүсэлтийг санаатайгаар хангаагүй, мэдээлэл хариуцагч хуульд заасан үүргээ зөрчсөн, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа илэрхийлэл, бэлгийн харилцааны талаарх мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашигласан, мэдээллийн эзэн болон бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, хуульд заасан нөхцөл бүрдсэн байхад мэдээллийн эзний мэдээллээ устгуулах хүсэлтийг хангаагүй. Мэдээлэл хариуцагч мэдээллийн эзэнд мэдэгдэл өгөх үүргээ зөрчсөн. Мэдээлэл боловсруулагч мэдээлэл цуглуулах боловсруулахад илэрсэн зөрчлийг мэдсэн даруйдаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр мэдээлэл хариуцагчид мэдэгдэх үүргээ зөрчсөн, мэдээллийг хуулийн дагуу олж мэдсэн этгээд бусдад задруулсан зэрэг хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийг зөрчсөн үйлдэлд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалт Монгол Улсад байхгүй байгаа. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан. Гэвч эдгээр зохицуулалтууд бодит байдал дээр төдийлөн үр нөлөөгүй байгааг энэ илтгэлд мөн тусгасан.

3 дахь санал. Улам бүр нэмэгдэх үүрэг, хариуцлагыг нь тооцож, дэлхий нийтийн түгээмэл чиг хандлагын дагуу хүний хувийн мэдээллийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл хамгаалах эрх бүхий бие даасан байгууллагыг Засгийн газрын бүтцэд байгуулж, бэхжүүлэх талаар үе шаттай хэрэгжүүлэх бодлогыг тогтоох. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага гэх хуулийн мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага гэх 6 дугаар бүлэгт Хүний эрхийн Үндэсний Комисс, Цахим хөгжил, инновац, харилцаа.../минут дуусав/

Ж.Золжаргал: Нэмэлт цаг өгье.

Г.Нарантуяа: 15 минутад илтгээрэй гэсэн ийм чиглэл ирсэн гэж бодсон. Тэгээд 12, 13 минут болох байх гэж тооцсон байгаа.

Гэвч Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага гэх 6 дугаар бүлэгт Хүний эрхийн Үндэсний Комисс, Цахим

хөгжил, харилцаа холбооны яам, төрийн бусад байгууллагыг уг хуулийг хэрэгжүүлэхэд оролцох чиг үүргийг заасан бөгөөд аль нэг байгууллагыг мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага гэж нэрлэж хуульчлаагүй. Гэвч энэ хуулиар Хүний эрхийн Үндэсний Комиссын чиг үүрэг үүргийг тогтоосон байдлаас комиссыг Монгол Улсын мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлж байна гэж практикт үзэх боломжтой байгаа.

Монгол Улсад хүний хувийн мэдээллийг хамгаалах эрх зүйн харилцаа бий болж байгаа энэ эхэн үед комисс манлайлж, мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх нь хувийн мэдээллийг хамгаалах үйл ажиллагааг хүний эрх, эрх чөлөөний өргөн хүрээтэй үзэл санаанд суурилж явуулах институтын соёл уламжлалыг төлөвшүүлэхэд ач холбогдолтой байж болно.

Гэвч цахим технологи төр, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд нэвтэрч, харилцаа хөгжихийн хэрээр Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулдаг, торгох шийтгэлийг хэлж байна. Аудит хийх, магадлан итгэмжлэх гадаад улсад мэдээлэл дамжуулахад зөвшөөрөл олгох зэрэг захиргааны шинжтэй үйл ажиллагаа явуулдаг мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага шаардлагатай болох юм. Мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллагын үүргийг Хүний эрхийн Үндэсний Комисс хэрэгжүүлэх нь Үндсэн хуулиар тогтоосон төрийн байгууллагын мөн чанар, хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хараат бус хяналт тавих хүний эрхийн үндэсний байгууллагын үндсэн зорилгод нийцэхгүй төдийгүй Монгол Улсад хүний хувийн мэдээллийг хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангах үр дүнтэй механизмыг бий болгоход оновчгүй ойрын хугацааны шийдэл билээ.

4 дэх санал. Хүнийг тагнах, мөрдөн мөшгөх боломжтой бүх төрлийн цахим төхөөрөмж нийтийн болон хувийн орон зайд байрших дуу, дүрсний бичлэгийн систем, хүний биометрик мэдээллийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, халдашгүй чөлөөтэй байх эрх чөлөөг хамгаалах. Хүний хувийн мэдээлэл их хэмжээгээр бүртгэгдэж цуглардаг цахим технологийн эриний хүний эрхийн гол эрсдэлийн нэг бол хүнийг хууль бусаар тагнах, мөрдөн мөшгөх явдал юм. Гэвч GPS технологид суурилсан байршил тогтоогч төхөөрөмж, эйр таг, мал амьтны хүзүүвч, машин техникт холбох зориулалт бүхий олон төрлийн төхөөрөмжийг зах зээл дээр чөлөөтэй худалдаалж байгаа. Тэгэхээр энэ мэт эдгээр энгийн хэрэглээний болон тусгай зориулалтын тагнах, мөрдөн мөшгөх, төхөөрөмжийг импортлох, худалдан авах, хэрэглэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт Монгол Улсад бий болоогүй гүйцэтгэх ажлын зорилгоор тагнах төхөөрөмжийг ашиглах зохицуулалт хэт ерөнхий хүний халдашгүй чөлөөтэй байх эрхэд эрсдэл учруулахуйц байна.

5.Хиймэл оюуны хөгжүүлэлт, ашиглалт, хүн төвтэй, ялгаварлан гадуурхалтаас ангид, мэдээлэл, өгөгдлийн боловсруулалт, ил тод, хариуцлагатай байх зарчмуудыг үндэсний хиймэл оюуны стратегид тусгах, улмаар Монгол Улсад хөгжүүлэх ашиглахыг хориглох хиймэл оюуны төрөл зорилгыг тогтоосон хиймэл оюуны хөгжүүлэлт, ашиглалтад хүний эрхийг хангах, удирдамжийг батлах, хүний эрхэм чанарыг хүндэтгэх, тэгш байдал, мэдээлэл авах эрхийг хангах, хиймэл оюун ашиглаж хийсэн боловсруулалтын талаар гомдол гаргах, шударгаар шийдвэрлүүлэх боломжийг бий болгох, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах зарчмуудыг хиймэл оюуны үндэсний стратегид тусгах нь зүйтэй.

Түүнчлэн хүмүүсийн зан байдал хувийн шинж чанараар нь үнэлж онооны систем бий болгох хүний шийдвэр гаргах чадварыг санаатай сулруулж, манифуляц хийх зорилготой хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг нийгмийн бүлгийн эмзэг байдлыг далимдуулж ашиг орлох зорилготой, сургууль, ажлын байранд хүний сэтгэл хөдлөлийг тандах бүртгэх зорилготой, хүний нүүр царай биометрик мэдээллийг төрөл бүрийн цахим эх сурвалжаас зөвшөөрөлгүйгээр татаж, хүний царай төрхийн өгөгдлийн сан үүсгэх, өргөжүүлэх зорилготой хиймэл оюуны системийг Европын холбооны улсуудад хөгжүүлэх, ашиглахыг хориглож, чанд хязгаарлалт тогтоож байгааг анхаарч, хиймэл оюуны хөгжүүлэлт, ашиглалтад хүний эрхийг хангах удирдамжийг батлах нь зүйтэй байна.

6 дахь санал. Нэг талаас үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих, нөгөө талаас худал мэдээлэл, хүчирхийлэл, үзэн ядалтыг дэвэргэх илэрхийлэл, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй хоруу контентыг хязгаарлах, зохист тэнцвэрийг хангасан байдлаар олон нийтийн сүлжээг зохицуулах, бодлогыг тодорхойлох. Иргэдийн мэдээлэл авах, харилцах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжихийн хамт худал мэдээлэл, хүчирхийлэл, талцал, сөргөлдөөн бий болгох зорилготой хоруу контентыг зохицуулах бодлогыг Монгол Улс тодорхойлох нь нэн тулгамдсан асуудал юм.

Комиссын гишүүн Х.Мөнхзулын танилцуулах цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийлэл илтгэлд энэ талаар тулгамдсан асуудлыг дэлгэрэнгүй танилцуулах болно.

Олон нийтийн сүлжээг зохицуулах ардчилсан Монгол Улсын бодлогын хувилбарыг дэвшүүлэх зорилгоор тухайлсан судалгааны ажлыг Хүний эрхийн Үндэсний Комисс, Үндэсний болон Европын холбооны экспертийн оролцоотой явуулж байна. Энэ оны 12 сард болох Хүний эрхийн үндэсний 3 дугаар форумд энэ ажлын үр дүнг танилцуулах болно.

7 дугаар санал Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, орлого багатай болон хөдөөгийн өрх Монгол хэлээр харилцах боломжгүй хүмүүсийн цахим технологи.../минут дуусав/

Ж.Золжаргал: 5 дугаар микрофон нэмж өгье.

Г.Нарантуяа: Баярлалаа. Хэрэглэгдэхүүн боловсруулах, үр дүнтэй сургах ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шинжлэх ухааны дэвшлийн үр шимээс хүртэх эрхийг хангахад чиглэгдсэн цахим хуваагдлыг сөрөх бодлогыг баталж хэрэгжүүлэх, комиссын судалгаагаар төрийн цахим үйлчилгээ ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжгүй, нийцгүй байна. Тухайлбал ахмад настны 69 хувь, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 80,3 хувь нь төрийн цахим үйлчилгээг авах хэрэгцээ байдаг ч веб хуудас, аппликэйшний харагдах байдал, үсэг томруулах тохиргоогүй, сонгосон текстийг дуу хоолойгоор унших үйлдлийн систем байхгүй, цахим технологи ашиглах мэдлэг ур чадвар дутагдалтай, интернэт тоног төхөөрөмж байхгүй байгаа нь саад болж байна.

Нөгөө талаас орчин үеийн цахим технологи хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настны амьдралын чанарыг дээшлүүлж, амьдралын өдөр тутмын харилцаанд бусдаас хамааралтай байдлыг бууруулж, бие даан илүү эрх чөлөөтэй амьдрах боломжийг нэмэгдүүлэх боловч ийм технологийг хөгжлийн бэрхшээлтэй

хүмүүс ахмадууд хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх төрийн бодлого дутагдалтай байна.

8 дахь санал. Ковид 19. Цар тахлын үеэр цугларсан хувийн мэдээллийн сан, түүний ашиглалтыг Засгийн газрын дотоод хяналтын хүрээнд хянаж, үр дүнг Улсын Их Хуралд танилцуулах, Ковид 19 цар тахлын үеэр төрөөс иргэдийн мэдээллийг цаасан болон цахим байдлаар цуглуулсан. Эдгээр мэдээллийг хэрхсэн, ямар мэдээллийг хэн, хэдий хугацаанд хадгалах болон устгах талаар тодорхой бодлого, хэрхэн хадгалж ашиглаж байгаад хяналт тавих нь иргэдийн цахим төрд итгэх итгэлийг бэхжүүлэх, хүний хувийн мэдээллийг талаарх төрийн албан хаагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх жишиг болох юм.

Тийм учраас энэ асуудалд Засгийн газар онцгойлон анхаарал хандуулж, дотоод хяналтынхаа хүрээнд шалгах нь зүйтэй. Ялангуяа энэ үеэр үүссэн зарим төрлийн мэдээллийн санг эрх зүйн зохицуулалт хяналтгүй ашиглагдаж байж болзошгүй мэдээллийг Хүний эрхийн Үндэсний Комисст ирж байгааг бас мөн илтгэлдээ тусгасан болно.

Ингээд Байнгын хорооны гишүүдийг комиссын саналыг хэлэлцэж, шийдвэр гаргаж өгөхийг хүсье. Танилцуулж дууслаа. Баярлалаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. Нарантуяа гишүүнд баярлалаа. Одоо цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийллийн нөхцөл байдлын талаар Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Мөнхзул танилцуулга хийнэ. Микрофон нээж өгье. 6 дугаар микрофон.

Х.Мөнхзул: Баярлалаа. Цахим хөгжлийн 1 сүүдэртэй тал нь цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийллийн асуудал байгаа.

Тэгэхээр энэ жендерт суурилсан хүчирхийллийн асуудал буюу гэр бүлийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн хүчирхийлэл зэрэг жендерт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүд бол цахим технологио дагаад, сүүлийн жилүүдэд арга хэлбэр нь бол өөрчлөгдөж байна. Тэгэхээр цахим технологи нь бол ялангуяа охид, эмэгтэйчүүд, хүүхдүүд бол цахим орон зайг улам аюултай болгож, хүчирхийлэлд өртөх нэг талбар болгож байна. Энэ нь зөвхөн Монгол Улсад ч төдийгүй дэлхий нийтэд бас анхаарал хандуулж байгаа асуудал байгаа учраас Нэгдсэн Үндэсний байгууллагаас бол энэ цахим технологи ашиглаж буй жендерт суурилсан хүчирхийллийн асуудлаар улс орнуудыг анхаарлаа хандуулж, хууль, эрх зүйн орчноо сайжруулах, хохирогч хамгааллын асуудлаа сайжруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зайлшгүй авахыг бол бас улс орнуудад бол уриалж байгаа. Монгол Улсад бол Нэгдсэн Үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрөөс цахим технологи ашиглан үйлчилж байгаа цахим орчин дахь хүүхдүүдийн дарамт, хүчирхийлэл ямар байна вэ гэдэг энэ судалгааг 2024 онд бол явуулсан. Энэ судалгаанд оролцогчдын 54,9 хувь нь бол энэ цахим дээрэлхэл, дарамтад өртөж байна. 5 хувь нь бол бэлгийн хүчирхийлэл, дарамтад өртсөн гэсэн ийм тоо статистикууд бол байна. Тэгэхээр олон нийтийн сүлжээнд цахим орчинд цахим технологи ашиглаж, хүний нэр төрд нь халдах, гүтгэх, доромжлох, өдөөн хатгах, ялгаварлан гадуурхах, үзэн ядсан бичвэр нийтлэх, садар самуун зураг илгээх, цахим дээрэлхэл, цахим өргөдөл зэрэг энэ асуудал нь бол жендерт суурилсан хүчирхийллийн агуулгыг нэлээн өөрчилж байна.

Тэгэхээр дэлхий нийтээр бол 30 гаруй цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийллийн нэр томьёонуудыг бол гаргасан байгаа. Тэгэхээр энэ нэр томьёонуудыг бас эргэн харж, хууль эрх зүйн орчноо сайжруулахыг бол бас улс орнуудад анхааруулж байгаа. Энэ үүднээс бол Хүний эрхийн Үндэсний Комиссоос одоо үүсээд байгаа шинэ нөхцөлд Монгол Улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль болон гэмт хэргийг мөрдөн шалгах, хохирогчийг хамгаалах асуудал бол анхаарал хандуулж, бид нар энэ илтгэлийг бол бичсэн.

Тэгээд энэ дээр бол цахим технологи ашиглан үйлдэж буй жендерт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал, хууль, эрх зүйн орчин, мөрдөн шалгах ажиллагаа, хохирогчид тусламж үзүүлэх, урьдчилан сэргийлэх асуудлын хүрээнд бол авч үзсэн байгаа.

Ингээд 4 саналыг Улсын Их Хурлаар бас нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна гэсэн саналыг оруулж байна.

1 дүгээрт бол цахим жендерт суурилсан хүчирхийлэл үйлдэж буй арга хэлбэр, хор уршиг, хохирол, хохирогчийн онцлогийг нарийвчлан судалж, Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд бол энэ төрлийн гэмт хэрэг үйлдэлтэй тэмцэх шаардлагыг бол хангахуйц нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж байна.

2.Мөн Эрүүгийн хуулийн ялгаварлан гадуурхах, хүний амиа хорлох нөхцөлд хүргэх, гэр бүлийн хүчирхийлэл, заналхийлэх зэрэг ийм гэмт хэргүүдийг бол цахим технологи ашиглан үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл авч үзэх ийм нарийвчилсан зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

3.Мөн цахим технологийн орчин ашиглаж үйлдэгдэж буй гэмт хэргийг мөрдөн шалгах, цахим нотлох баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, үнэлэх аргачлал боловсруулж, үе шаттай сургалт явуулах, цагдаагийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх олон нийтийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь зүйтэй байна.

4 дүгээрт жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд, эмэгтэйчүүд, залуучуудад зориулсан мэдээлэл нөлөөллийн үйл ажиллагааг төлөвлөн үүрэг хүлээгч талуудыг оролцуулан хэрэгжүүлэх ийм зайлшгүй шаардлагатай байна гэсэн саналыг оруулж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Золжаргал: Мөнхзул гишүүнд баярлалаа. Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Анар гишүүн асуулт асууна.

Ч.Анар: Оройн мэнд. Хүний эрхийн Үндэсний Комисс эрх зүйн хувьд иргэдийн, хүний мэдээллийн аюулгүй байдал хүний эрх зөрчиж байгаа асуудлаар дүгнэлт хийгээд, нөгөө харьяалах байгууллагуудад нь хүргэх ямар эрх зүйн статустай юм бэ. Жишээ нь одоо улам бүр хөгжиж байгаа хүссэн, хүсээгүй ирж байгаа технологийн эрин үед ялангуяа хиймэл оюун ухаантай камерууд их тавигдаж байна. Үндэсний аюулгүй байдлын чиглэлээсээ тодорхой хэмжээний зөвлөмжүүдийг өгдөг ч гэсэн хэрэгжүүлж чаддаггүй. Үндэсний аюулгүй байдлын цаана бас хүний эрхийг зөрчсөн асуудлууд их явагддаг. Тухайн хүний хаана байгаа, зан төрх, төлөв байдлыг нь мэдэх. Түрүүн та бүхний итгэлд бас дурдагдаж

байх шиг. Энэ мэдээллүүд хаана байгаа нь, бас хаашаа алдагдаад байгаа нь тодорхойгүй.

Тэгэхээр одоо үндсэндээ бол энэ асуудлаар бол Тагнуулын ерөнхий байгууллага бол тодорхой хэмжээний технологиуд дээр зөвлөмж л хүргүүлэх эрх зүйн статустай. Тэрийг нь заавал хэрэгжүүлэх албагүй. Тэгэхээр танайх бас иймэрхүү хүний эрх, хувь хүний мэдээллийн аюулгүй байдалтай холбогдсон энэ асуудлууд дээр эрх зүйн зөвлөмж хүргүүлэх юм уу, хяналт шалгалт хийх эрх зүйн статус байдаг юм уу. Процесс байгаа юу.

Ж.Золжаргал: 5 дугаар микрофон дээр хариулна. Нарантуяа гишүүн.

Г.Нарантуяа: Тэгэхээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комисс, Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих ийм ерөнхий бүрэн эрхтэй.

Мөн Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйл, мөн холбогдох бусад зүйлүүдэд хүний хувийн мэдээллийг хамгаалах талаар Хүний эрхийн Үндэсний Комисс ямар үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоосон. Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссын хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих хамгаалах бүрэн эрхэд нийцүүлээд хүний хувийн мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй, цагдаагийн байгууллага шалгахгүй, тагнуулын байгууллага шалгахгүй, хүний хувийн мэдээллийн зөрчилд хяналт тавих, Комиссын гишүүний шаардлага зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлэх, мөн хүний оролцоогүйгээр хүний хувийн мэдээллийг цуглуулж байгаа энэ цахим технологийн нэвтрэлтийн талаар бол үнэлэлт дүгнэлт өгөх гээд үндсэндээ 9 чиг үүргийг Хүний эрхийн Үндэсний Комисс хэрэгжүүлж байгаа.

Гэхдээ яг энэ илтгэлд тусгагдаж, комиссын санал оруулж байгаагаар бол хиймэл оюуны асуудлыг хариуцсан асуудлыг зохицуулах, олон нийтийн сүлжээг зохицуулах гээд сүүлийн үеийн цахим технологитой холбоотой асуудлыг зохицуулах, мэдээлэл хариуцах эрх бүхий байгууллагыг Монгол Улсад зохих ёсоор хөгжүүлэх, бэхжүүлэх ийм шаардлага бол гарцаагүй тулгарч байгаа.

Ж.Золжаргал: Анар гишүүн тодруулж асууна.

Ч.Анар: Тэгэхээр таны хэлж байгаа энэ 9 чиг үүрэг бүхий зөвлөмж, дүгнэлтүүд маань яг үнэхээр бодит байдал дээрээ тухайн төрийн байгууллага болон хувийн хэвслүүд авч хэрэгжүүлэх чадамж бол байхгүй байгаа учраас тусгай чиг үүрэг бүхий агентлаг ч юм уу болох ёстой юм байна гэж шаардлагыг хүргүүлж байна гэж ойлголоо. Зөв үү. Өөрөөр хэлбэл бодитой үр дүн гарахгүй байна гэж үзэж байна гэсэн үг үү. Та хэд судалгаа хийгээд, хяналт шалгалт, дүгнэлт хийгээд байдаг. Гэтэл энэ нь бодит байдлаар хэрэгжих эрх зүйн статус дутуу байна гэж үзэж байгаа гэсэн үг үү.

Ж.Золжаргал: 5 дугаар микрофон дээр нэмж хариулна.

Г.Нарантуяа: Тэгэхээр ямар ч байсан одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комисс гомдол, мэдээллийг хүлээж авч, шалгаж шийдвэрлэж байгаа. 100-аад гомдлыг хүлээж авч өнгөрсөн хууль хэрэгжсэнээс

хойш 100-аад гомдлыг хүлээж авч, Хүний эрхийн комиссын харьяалан шийдэх асуудал гэж үзсэн асуудлаар Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт бол харьцангуй боломжийн түвшинд байгаа. Гэхдээ мэдээлэл хариуцах ялангуяа цахим технологийн хөгжилтэй холбоотойгоор дэлхийн улс орнууд мэдээлэл хариуцах эрх бүхий байгууллагыг байгуулдаг. Энэ байгууллага бол хүний эрхийн үндэсний байгууллага, Хүний эрхийн Үндэсний Комиссын чиг үүргээс арай өвөрмөц захиргааны шууд шинжтэй ажлуудыг хийдэг юм. Өөрөөр хэлэх юм бол Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн шаардлага, зөвлөмж гаргах замаар тухайн хүний эрхийг зөрчсөн этгээдээр арга хэмжээ авхуулдаг бол мэдээлэл хариуцах эрх бүхий байгууллагууд бол торгох ийм эрхийг хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлэх юм бол мэргэжлийн.../минут дуусав/

Ж.Золжаргал: 5 дугаар микрофонд нэмэлт цаг.

Г.Нарантуяа: Мөн магадлан итгэмжлэх, зөвлөмж өгөх, зөвшөөрөл өгөх ийм захиргааны шинжтэй ажлуудыг хэрэгжүүлдэг. Data protection authority буюу regulatory commission бол ажилладаг. Тэгэхээр шууд хувийн хэвшлийн байгууллагуудтай албадлагын арга хэрэгслээр ажиллах ийм боломжтой байгууллагыг байгуулах нь 1 дүгээрт нь онолын талаасаа хүний эрхийн үндэсний байгууллага гэдэг бол тогтолцоог хянадаг байгууллага. Тэгэхээр эхэн үедээ өнөөдрийн комиссын илтгэл оруулсан дүгнэлт бол энэ хөгжлийн эхэн үед бол Хүний эрхийн Үндэсний Комисс энэ асуудлыг хариуцах нь байж болох ч гэсэн яваандаа улам бүр энэ харилцааг гүнзгийрнэ. Улам бүүр шууд ажиллах шаардлагатай болох учраас яг тэр зүй зохисынх нь дагуу байгуулах нь Монгол улсын ирээдүйд хэрэгтэй гэдэг ийм дүгнэлтийг хийгээд, саналыг оруулсан юм.

Ж.Золжаргал: 5 номерын микрофон.

Г.Нарантуяа: Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэлийн 3 дугаар бүлгийн 2 дугаар хэсэгт манайд байгаа Эрүү, Зөрчлийн хууль, Төрийн албаны хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн хуулиар тогтоосон албадлагын арга хэрэгсэл, мэдээлэл хариуцах эрх бүхий байгууллагыг тогтоосон байдал яагаад болохгүй байгаа вэ, яавал зохистой вэ гэдгийг бол маш тодорхой бичсэн байгаа. Энэ илтгэл уг нь энэ цонхон дээр байна. Их Хурлын гишүүдэд тараагдсан байх гэж бодож байна. Та бүхэн бас энийг анхааралтай уншиж, өөрсдийнхөө санал дүгнэлт, ялангуяа энэ хороонд бол мэргэжлийн энэ чиглэлд ажилладаг гишүүд байгаа учраас бид бас маш идэвхтэй ийм яриа хэлэлцээ хийх, ялангуяа энэ асуудлыг олон нийтийн анхааралд шийдвэр гаргах эрх бүхий хүмүүсийн анхааралд хүргэх ийм гарцаагүй шаардлагатай байгаа юм.

Ж.Золжаргал: Мэдээлэл өгсөнд баярлалаа. Үг хэлэх гишүүд байна уу. Анар гишүүн үг хэлнэ. Анар гишүүн үг хэлнэ. Дараа нь Золжаргал.

Ч.Анар: Хүний эрхийн Үндэсний Комисст маш хэрэгтэй мэдээлэл өгсөнд талархлаа. Тэгэхээр төрийн үйлчилгээ, төрийн процессыг хүн төвтэй болгох процессын дахин инженерчлэл гэж ажлын хэсэг гарсан байгаа. Золжаргал гишүүн Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга болон миний бие ахлаад явж байгаа юм. Тэгэхээрээ түүн дээр үзэл баримтлал боловсруулах гэж байгаа энэ ажлын хэсгийн дүгнэлт маань ирэх 7 хоногт гараад, Их Хурлын тогтоол болгож гарах гэж байгаа учраас та бүхэн манай ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үзэж

танилцаад саналаа өгөх нь бол зайлшгүй юм байна гэж би үзэж байна. Золоо дарга бас санал нэгдэх байх.

2 дугаарт одоо бол хүссэн, хүсээгүй та бүхний ч ярьж байгаа ирээдүйг цахимжиж, технологийн эрин үе ирж байна. Ялангуяа Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрүүдэд маш олон зүйл цахимжихаар AI, Big data гэж орж ирж байгаа. Гэхдээ миний хувь гишүүний хувьд аюулгүй байдал буюу кибер аюулгүй байдалд санаа зовж байгаа. Үүнтэй адилхан мэдээллийн аюулгүй байдал гэдэг ойлголт байгаа. Энэ хоёулаа бол маш ноцтойгоор хөндөгдөж байгаа. Тэгэхээр мэргэжилтний зүгээс кибер аюулгүй байдалд анхаарч байгаа ч гэсэн мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр нь Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтарч ажиллах зайлшгүй шаардлагатай байна гэж үзэж байна.

Ялангуяа сүүлийн үед энэ хиймэл оюун ухааны технологи Монголд бол сошиал медиа ашиглах биш, хувь хүний мэдээллийг ашиглан олон нийт дэх мэдээллээс гадна эрүүл мэнд болон зан төлөвийн мэдээ мэдээллийг ашиглан далд ухамсарт олон нийтийн далд ухамсарт нөлөөлөх арга техник хэрэгжиж байж болзошгүй гэсэн хардлага байгаа. Тодорхой хэмжээний судалгаанууд бас хийгдэж байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр та бүхэн бас судалгаа хийхэд оролцохгүй бол Монгол Улсад Монгол Улсын нийт ард иргэдэд далд ухамсарт нь зан төлөв болон үзэл бодлыг нь өөрчлөх хэмжээний технологийн хэрэгжилтийг Монгол Улсад хийж байна гэж үзэж байгаа юм. Энэ нь бол үндэстний эрх ашгийг зөрчиж байгаа тиймэрхүү асуудал. Бид нар өөрөө мэдээллийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдлын тухай хуулийн эрх зүйн байдлын хоцрогдлын улмаас тэр нөхцөл байдлыг аль хэдийн нээгээд өгчихсөн байгаа. Тэгэхээр энэ дээр та бүхэн тодорхой хэмжээгээр анхаарал хандуулж ажиллаасай гэж хүсэж байна.

Тэгэхээр бас Инновац, цахим бодлогын байнгын хороонд энэ захиргааны эрх бүхий байгууллага байгуулах болсон үндэслэл, ямар хууль, эрх зүйн үндэслэлийг гаргаж ирэх вэ гэдэг санал байгаа. Ерөнхий санал биш илүү тодорхой санал гаргаж өгөх нь зүйтэй болов уу гэж би бодож байна. Баярлалаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. Саяын асуудалтай холбоотой Нэгдсэн Үндэсний байгууллагын хүний эрхийн тусгай элч гэдэг хүнтэй уулзаж байсан. Тэгээд тэр хүний дүгнэлт нь бас олон улсад бол хүний эрхийг хамгаалдаг ийм тусгай агентлаг маягийн байгууллага байдаг юм. Монгол Улсад бол энэ бас хэрэгтэй юм байна. Хүний хувийн мэдээллийг хамгаалах чиглэлээр ажилладаг гэж. Тэгэхээр энэ дээр энэ дүгнэлт дээрээ та бүхэн бас тусгасан юм байна. Анар гишүүний хэлсэнчлэн тодорхой санал зөвлөмж байвал бас бидэнд хүргүүлбэл цаашаа хэрэгжүүлээд явахад илүү дөхөм болох болов уу.

2 зүйлийг бас онцолж тэмдэглэмээр байна. Жендерт суурилсан хүчирхийллийн хувьд ялангуяа цахим орчинд хүүхдийн бэлгийн мөлжлөг, нөлөөлөл бол хүчтэй байдаг талаар нэлээн мэдээлэл авсан. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс болон урд нь бас өөр эх үүсвэрүүдээр. Тэгэхээр энэ дээр тэр цахимаар үйлдэгдэж байгаа гэмт хэрэг нь ямар нөлөө үзүүлдэг юм. Сэтгэл санаа нь болоод бие махбодод тэрийг нөлөөг нь үнэлдэг нэг арга замтай болох, тэрэндээ тохирсон шийтгэл хариуцлагыг гаргаж ирэх гээд энэ эрх зүйн орчныг сайжруулахын өмнө нэлээн их хэмжээний судалгаа хийгдэх иймэрхүү дүгнэлт байна гэж харлаа.

Мөнхзул гишүүний хэлсэн танилцуулгын 1 дүгээр санал байсан. Энэ дээр бол нэлээн том ийм ажил хийгдэх ёстой зайлшгүй шаардлагатай юм байна гэж.

Анхаарал хандуулмаар бас нэг зүйл хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай Нарантуяа гишүүний танилцуулга дээр хувийн мэдээллийг мэдээлэлд халдахад өгөх ял шийтгэлийг чангалах талаар, тэгээд хүчирхийлэл агуулсан контентын зохицуулалт гээд энэ бол мэдээж их чухал саналууд гэж бодож байна. Гэхдээ нөгөө талдаа энийг их тийм зохистой ашиглахгүй бол буцаад хүний эрх рүү халдсан хязгаарлалт болчих эрсдэлтэй. Тэгэхээр энэ дээр бид нар энэ балансыг нь яаж барих, олон улсын жишиг жишээг бол туршлагыг бол их нарийн судлах хэрэгтэй юм болов уу гэсэн ийм зүйл бол бодогдож байна.

Хиймэл оюуны оюуныг ашиглаад массын сэтгэл зүйд нөлөөлөх, манифуляц хийх, бүр хиймэл оюун нь өөрөө манифуляц хийдэг ийм үзэгдэл бас гарч ирээд явж байгаа. Тэгэхээр энийг бол бид нар хиймэл оюуны зохицуулалт бодлого дээр бас зохих хэмжээгээр тусгаж өгөх нь зүйтэй юм байна гэж бодож байна.

Ингээд та бүхэнд мэдээлэл хийсэнд баярлалаа.

Гишүүд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой үг хэлж, асуулт асууж дууслаа.

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 24 дэх илтгэлийн асуудлыг хэлэлцэж, илтгэлийг хэлэлцсэн талаар Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа танилцуулна.

Ингээд комиссын дарга, гишүүдэд баярлалаа. Илтгэлийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

17.49 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ